



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

“Санхүүгийн зохицуулах хорооны
үйл ажиллагааны стратеги” батлах тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2006 оны 45 тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.1.4 дэх заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги (2012-2016 он)”-г хавсралтаар баталсугай.
2. “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги (2012-2016 он)” батлагдсантай холбогдуулан салбар тус бүрийн чиглэлээр 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж 2012 оны 3 дугаар улиралд багтаан Хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.
3. Хорооны стратегид тусгагдсан ажлуудыг Ажлын албаны жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж Хорооны хуралдаанд танилцуулж байхыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.



ДАРГА

ДБАЯРСАЙХАН

“САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ”
(2012-2016 он)

Улаанбаатар хот, 2012 оны 3 дугаар сар

Агуулга	3
Товчилсон үгийн жагсаалт	4
Хүснэгт	5
1. ОРШИЛ	6
1.1. "Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги"-ийн зорилго	6
1.2. Аргачлал	7
2. МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, САНХҮҮГИЙН ОРЧИН, НӨХЦӨЛ БАЙДАЛ.	11
2.1. Макро эдийн засгийн үзүүлэлт	11
2.2. Нийгмийн салбарын үзүүлэлт	13
2.4. Монгол Улсын улс төрийн орчин, нөхцөл байдал	14
2.5. Санхүүгийн зах зээлийн бүтэц	15
2.6. Банкны салбар	15
2.7. Банкнаас бусад санхүүгийн салбар	18
2.8. Товч дүгнэлт	32
3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ	36
3.1. Бүрэлдэхүүн хэсэг	36
3.2. Эрхэм зорилго	36
3.3. Стратегийн зорилго	37
3.4. СЗХ-ны үнэт зүйлс	37
3.5. СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар	38
3.6. Үндсэн болон туслах үйл ажиллагааг ангилан ялгах буюу сегрегаци хийсэн нь	40
3.7. Бодлого боловсруулах болон хяналт тавих үйл ажиллагааны зааг ялгаа	41
3.8. Хяналтын үйл ажиллагааг аль болох мэргэжлийн холбоодод шилжүүлэх	43
3.9. Хамгийн боломжит дээд хэмжээний үр ашиг бүхий орчинд зохицуулалт хийх боломж бий болгох	44
3.10. Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	45
4. ЗОХИЦУУЛАЛТЫН СТРАТЕГИ	48
4.1. Зохицуулалтын үйл ажиллагааг бэхжүүлэх	48
4.2. Үндсэн үйл ажиллагааны стратеги	50
4.3. Туслах буюу үндсэн бус үйл ажиллагааны стратеги	58
4.4. Үндсэн болон туслах чанарын стратегийн аль алинд нь хамрагдах асуудал	611
5. ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ	63
5.1. Захиргааны үйл ажиллагааны стратеги	63
5.2. Мэдээллийн технологи	66
5.3. Судалгаа, шинжилгээний үйл ажиллагааны стратеги	66
5.4. Эрх зүйн стратеги	698
5.5. Олон нийтийн сургалт ба олон нийттэй харилцах харилцааны стратеги	69
6. ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА	71
Тайлбар толь	74
Ашигласан ном, хэвлэл	77
Хавсралт	78

АОУС	Аудитын олон улсын стандарт
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БЗБ	Бичил зээлийн байгууллага
ГХГШҮ	Гүйцэтгэл хэмжих гол шалгуур үзүүлэлт
ГХШҮ	Гүйцэтгэлийн хяналтын шалгуур үзүүлэлт
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ЕХ	Европын холбоо
ЛХБ	Лондонгийн хөрөнгийн бирж
МБ	Монголбанк
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн Банк
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МХТ	Мэдээлэл холбооны технологи
ОТХОСБ	Олон талт харилцан ойлголцлын санамж бичиг
ОУВС	Олон улсын валютын сан
ОУДХШХ	Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбоо
ОУСТС	Олон улсын санхүүгийн тайлагналын стандарт
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СМН	Санхүүгийн мэдээллийн нэгж
СҮҮ	Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч
ҮХО	Үүрэн холбооны оператор
ҮЦХОУБ	Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХН	Хүний нөөц
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ЭА	Электрон арилжаа
ЭСХ	Эрсдэлд суурилсан хяналт

Хүснэгт 1 : ҮХШХ-ноос гаргасан макро эдийн засгийн үзүүлэлтүүд	12
Хүснэгт 2 : Макро эдийн засгийн 2012-2016 он хүртэлх төсөөлөл	13
Хүснэгт 3 : Нийгмийн хөгжлийн үзүүлэлт, Монгол улс, 1990–2006	14
Хүснэгт 4 : Хүний хөгжлийн үзүүлэлт, 1995-2010	15
Хүснэгт 5 : Санхүүгийн зах зээлийн бүтэц (2008-2011).....	16
Хүснэгт 6: Мэргэжлийн оролцогч байгууллагын балансын хураангуй нэгтгэл.....	19
Хүснэгт 7 : Ойрын ирээдүй болон дунд хугацааны эмзэг байдлыг харуулсан эрсдэлийн үнэлгээний матриц	33
Хүснэгт 8 : Эрхэм зорилго, зорилт, гол үнэт зүйлс хоорондын уялдаа холбоо	38
Хүснэгт 9 : СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар	39
Хүснэгт 10 : СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар(Үндсэн болон туслах үйл ажиллагааны хоорондын ялгаа)	40
Хүснэгт 11 : СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар (Бодлого боловсруулах болон үндсэн үйл ажиллагааны хяналт хоёрыг ялган зааглах нь)	43
Хүснэгт 12 : СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар(Хяналтын ажил үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх нь	43
Хүснэгт 13 : СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар(Туслах чанарын үйл ажиллагааны стратеги, хамгийн дээд хэмжээний үр ашиг бүхий орчинд зохицуулах үйл ажиллагааны стратеги хэрэгжих боломжоор хангах ёстой)	44
Хүснэгт 14 : СЗХ-ны Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх нь	45
Хүснэгт 15 : Төрийн байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн загвар	46
Хүснэгт 16 : 2012 онд зайлшгүй хийх ажлууд	47
Хүснэгт 17 : Эрсдэлд суурилсан хяналтын зарчмууд	49
Хүснэгт 18 : Уламжлалт болон эрсдэлд суурилсан аргын ялгаа	49
Хүснэгт 19 : Төлбөрийн чадварын I ба II -ийн харьцуулалт.....	54
Хүснэгт 20 : Эрсдлийн удирдлагын үйл явц.....	72

1.1. “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги”-ийн зорилго

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль, тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох чиг үүргийг хэрэгжүүлдэг.

СЗХ нь 2006 онд банкнаас бусад санхүүгийн зах зээл (үнэт цаасны зах зээл, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо болон бусад)-ийг хянан зохицуулах үүрэгтэйгээр байгуулагдсан.

СЗХ байгуулагдсан цагаасаа эхлэн санхүүгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, зохицуулалт, хяналт, зохицуулалтын байгууллагуудад сайн засаглал, дотоод хяналтын тогтолцоог бий болгох, нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой хүндрэл бэрхшээлтэй тухай бүр тулгарч ирсэн.

Энэхүү хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд маш их цаг зарж, хүн хүч дайчилж байсан хэдий ч шаардлагатай тоног төхөөрөмж, удирдлага, ажиллах хүчний нөөц, ур чадвар, мэдлэг, хөрөнгө оруулалтын чанартай болон урсгал зардлыг санхүүжүүлэх төсөв, бусад эх үүсвэр дутагддаг байв.

Нөгөө талаар, манай улс далайд гарцгүй орны хувьд хөгжлийн хүндрэл бэрхшээлтэй асуудалтай тулгарсаар ирсэн ч өнөөгийн байдлаар уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж эхэлж буй нь эдийн засаг үсрэнгүй хөгжих боломж бүрдүүлж өгч байна. Өдөр ирэх тусам нэмэгдэж буй хөрөнгө оруулалт цөөн хэдхэн жилийн дараа гэхэд Монгол улсын экспортын хэмжээ огцом нэмэгдэхэд түлхэц болж өгнө. Жижиг эдийн засагт гарах энэхүү эрс өөрчлөлт/өсөлт манай орны хөгжлийн орчин нөхцлийг өөрчлөх тул ирээдүйн хөгжилд гүйцэтгэх төр, засгийн үүрэг өсөн нэмэгдэх төлөвтэй байна.

СЗХ-ны тухайд ч мөн адил хөрөнгийн зах зээлд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, ирээдүйн өсөлтийг залахад хувь нэмэр оруулах шаардлагатай уялдсан хүндрэл бэрхшээлтэй тулгарна.

Энэхүү үйл ажиллагааны стратеги нь дээр дурдсан хүндрэл бэрхшээл болон байгууллагын өмнө тавигдах зорилтоос урган гарч ирж буй юм. Уг стратегийн зорилтод СЗХ-ны чиг үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хамрах тул үйл ажиллагааны шинэ загвартай болох асуудал Хорооны өмнө тулгарч буй томоохон сорилт бөгөөд уг стратегийн зарим хэсэг нь гарцаагүй болсон өөрчлөлт, шинэчлэлтийн үйл явцыг СЗХ хэрхэн удирдан зохицуулах, тухайлбал, чухам ямар шинэ үйл ажиллагаа болон бүтэц ирээдүйд илүү тохиромжтой болох талаар тайлбар өгөхөд чиглэгдсэн болно.

1.2. Аргачлал

Стратеги төлөвлөлт гэдэг нь тухайн байгууллагын ирээдүйн төлөв байдлыг албан ёсны хэлбэрээр тодорхойлсон баримт бичгийг хэлнэ. Стратеги төлөвлөлт нь гурван гол асуултанд хариулт өгдөг. Үүнд:

- "Бид юу хийдэг вэ?"
- "Бид хэний төлөө үүнийг хийдэг вэ?"
- "Бид хэрхэн сайжруулах вэ?"

Хэдийгээр стратеги төлөвлөлт хийх олон арга байдаг ч бүгд төлөвлөлтийн дараах гурван үндсэн үе шатны үйл явцыг өөртөө агуулдаг:

- **Нөхцөл байдлын үнэлгээ**–Өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж дүгнэнэ.
- **Зорилт**–Зорилго эсхүл зорилтоо тодорхойлно. (зарим тохиолдолд эрхэм зорилго гэх нь ч бий.)
- **Төлөвлөгөө/ санал**–Зорилгодоо хүрэх боломжийг зураглан харуулна.

Өөр нэгэн хэрэглэж болохуйц боломжийн арга нь **“Зурагла-Дүгнэж цэгнэ-Бодож тунгаа-Төлөвлө”** хэмээн нэрлэдэг арга.

- **Зурагла гэдэг нь** хүсэн хүлээж буй хамгийн дээд хэмжээний үр дүнгийн талаар зураглал гаргахыг,
- **Дүгнэж цэгнэ гэдэг нь** өнөөгийн нөхцөл байдал ямар байгааг тодорхойлж, мөн хүрэхээр төсөөлж буй үр дүнд хүрэхэд чухам юу дутагдаж байгаа болох, яагаад гэдэг асуултад хариулахыг,
- **Бодож тунгаа гэдэг нь** дутагдаж буй зүйлийг бий болгохын тулд чухам ямар арга хэмжээ авах шаардлагатай байгааг тодорхойлохыг,
- **Төлөвлө гэдэгт**–Авах шаардлагатай арга хэмжээ, түүнд шаардагдах ямар эх үүсвэрүүд хэрэгтэй болох талаар авч үзэхийг тус тус хэлнэ.

Энэ чиглэлээр зарим нэгэн үнэлгээ, шинжилгээний ажил 2010, 2011 онуудад хийгдсэн. Гэхдээ Монгол улсын эдийн засаг, нийгэм, санхүүгийн орчин, нөхцөл байдал нь энэхүү баримт бичигт дурдсанчлан СЗХ-ны үйл ажиллагаанд өөрчлөлт, шинэчлэлт хийх нь гарцаагүй болсныг илтгэн харуулна.

Энэхүү аргад үндэслэн үйл ажиллагааны стратегиа тодорхойлох нь нэгд, урам зориг хайрласан, хоёрт, зорилтод суурилсан арга байх болно.

“Санхүүгийн зохицуулах хорооны хүлээлтийг тодорхой болгох нь”

Стратеги төлөвлөлт хийх үйл ажиллагааны явцад СЗХ-ны ажилтнууд дор дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- СЗХ-ны стратегитай холбоотой хүндрэл бэрхшээлтэй асуудлыг тодруулсан;
- Ирээдүй-хэтийн зорилгоо тодорхойлсон;

- СЗХ өөрийн “Хөх далай”-г, өөрөөр хэлбэл, нийгэмд бий болгох үнэ цэнээ тодорхойлоход хэрэг болохуйц олон чухал шинэ санаа гаргасан;
- СЗХ-ны одоогийн үйл ажиллагааны загварын сул болон давуу тал, учирч болзошгүй хүндрэл бэрхшээл, мөн нээлттэй байгаа боломж бололцоог тодорхойлсон;
- Ирэх жилүүдэд тэргүүлэх ач холбогдол өгөхүйц ажил, үйл ажиллагаа юу байж болохыг тодорхойлон жагсаалт гаргасан;
- Багийн уур амьсгалыг бүрдүүлж, оролцогчид бүгд СЗХ-ны стратеги, тэргүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагааны талаар нэгдсэн ойлголттой болж чадсан;
- Гүйцэтгэх ажил, хариуцах эзэн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулж албан ёсны болгосон.

СЗХ-ны ажилтнууд эрхэм зорилгоо биелүүлэх үүднээс үйл ажиллагаагаа өөрчлөн сайжруулах шаардлагатай талаар мэдэж авцгаасан. СЗХ-ны хувьд “СЗХ одоогийнхоос хамаагүй илүү хэмжээний нэмүү өртөг буюу үнэ цэнэ бий болгох боломжтой” талаар нэгдсэн ойлголтод хүрэх ач холбогдолтой байсан тул дээр дурдсан альтернатив аргыг оролцооны аргатай хослуулан хэрэглэсэн юм.

Ингэхдээ СЗХ-ны ажилтан бүрт өөрсдийн хариуцсан ажлын чиглэлээр юуг өөрчлөх шаардлагатай болохыг олж харах боломжийг олгосон үйл ажиллагааны стратегийн тус тусын загварыг бий болгох чиглэлийг баримталсан. Хэрвээ СЗХ-ны ажилтнууд энэхүү загварыг дэмжиж ажиллавал өөрчлөлт хурдацтай явагдах магадлал өндөр байх болно.

Дор дурдсан асуудлуудыг багтаасан өөрчлөлт шинэчлэлийн үндэс суурь нь бат бөх байхад хувь хүн буюу тухайн асуудал хариуцсан ажилтан бүр үүнийг хүлээн зөвшөөрсөн байх нь туйлын чухал юм:

- **Ойлгож хүлээн авах**–Яагаад өөрчлөлт хэрэгтэй вэ гэдгийг ойлгож хүлээн зөвшөөрөх
- **Сонирхол**–Өөрчлөлт шинэчлэлийг дэмжих, өөрчлөлтийн үйл явцад оролцох
- **Мэдлэг**–Хэрхэн өөрчлөн шинэчлэх талаар мэдлэгтэй байх
- **Чадвар**–Шинэ ур чадвар эзэмшиж, түүнийгээ ашиглах
- **Бэхжүүлэх**–Өөрчлөлт, шинэчлэлийг даах чадвартай байх

Энэхүү төлөвлөлтийн үйл ажиллагааг хийхдээ олж авсан мэдээллээ сайтар боловсруулж үр дүнтэй ашиглах, өөрийн боловсон хүчний нөөцийг илүүтэй уян хатан байдлаар авч үзэх зарчимд тулгуурласан. Ингэснээр СЗХ өөрчлөгдөн буй орчинд дасан зохицож, байгууллагынхаа бодит ирээдүйг хүлээн зөвшөөрч ажиллах чадамжийг бий болгох юм.

Үйл ажиллагааны стратегийг тодорхойлохдоо дор дурдсан 3 үе шаттай ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- **Нэг дэх үе шат**

Монгол улсын эдийн засаг болон санхүүгийн салбарын түүхэн хөгжлийг үнэлж дүгнэсэн бөгөөд энэ нь СЗХ-ны эрхэм зорилго, мөн энэхүү стратегийн тулгуур үндэс болж өгсөн.

- **Хоёр дахь үе шат**

Дараахи дөрвөн үндсэн асуудлыг тойрсон үйл ажиллагааны зураглал гарган зөвлөмж боловсруулсан:

- Зохицуулалтын үндсэн үйл явц/процесс;
- Хүний нөөц;
- Удирдлагын болон туслах чанарын ажил үүрэг;
- Удирдлагын мэдээллийн систем.

- **Гурав дахь үе шат**

- Ирэх 5 жилд баримтлах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болон хийх ажил;
- 2012 оны Үйл ажиллагааны/Ажлын төлөвлөгөө.

Төлөвлөсөн ажил цаг хугацаандаа хийгдэх боломжийг баталгаажуулах зорилгоор үйл ажиллагаагаа төслийн албан ёсны бүтэц бүхий зохион байгуулалтын хэлбэрт оруулсан бөгөөд төсөл хэрэгжиж дуусах үед хүрсэн байвал зохих үр дүнгээ тодорхойлсон (9 дүгээр сараас 12 сар хүртэлх хугацааг хамарсан). СЗХ-ны даргын 2011 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 130 дугаар тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдаж ажилласан.

Люксембургийн Хөгжлийн Агентлагаас хэрэгжүүлж буй “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх болон сургалтын төсөл/МОН-004”-ийн техникийн дэмжлэг тусламжийн хүрээнд нийт найман дэд ажлын хэсэг дараах асуудлыг хариуцан ажиллахаар байгуулагдсан. Үүнд:

- Үнэт цаасны зах зээл;
- Даатгалын зах зээл;
- Бичил санхүүгийн зах зээл;
- Хүний нөөц;
- Мэдээллийн технологи;
- Байгууллага;
- Зах зээлийн мэдээлэл;
- Банк.

Дэд ажлын хэсэг нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:

- СЗХ-ны Эрхэм зорилгыг тодорхойлох;
- Стратегийн зорилтыг тодорхойлох;
- Гол үнэт зүйлсийг тодорхойлох;
- СЗХ-ны ажлын урсгалын загварыг боловсруулах;
- Зохицуулалтын үйл ажиллагааны стратегийг тодорхойлох;
- Туслах үйл ажиллагааны стратегийг тодорхойлох;
- 2012 оны Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.

2011 оны 10 дугаар сарын 28-нд “Нүхт цогцолбор”-т, мөн оны 12 дугаар сарын 22-нд “Өргөө зочид буудал”-ын уулзалтын танхимд Хорооны дарга, гишүүдэд “СЗХ-ны үйл ажиллагааны стратегийн төсөл”-ийг танилцуулан баталгаажуулж, эцэслэн боловсруулсан.

Үйл ажиллагааны стратегийн загварыг боловсруулахад зарим судалгааны материал, бусад улс орны тэргүүн туршлага зэргийг харгалзан үзсэн болно.

2. МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, САНХҮҮГИЙН ОРЧИН, НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1. Макро эдийн засгийн үзүүлэлт

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын дараа манай улсын эдийн засаг богино хугацаанд сэргэн, өндөр өсөлтөд хүрээд байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийн өсөлтийг дэмжих макро эдийн засгийн оновчтой бодлого, арга хэмжээний үр дүн бөгөөд 2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр манай улсын эдийн засаг 17.3 хувиар өсч, ДНБ-ий хэмжээ нэрлэсэн үнээр 10829.7 тэрбум төгрөгт хүрлээ.

Хүснэгт 1 : ҮХШХ-оос гаргасан макро эдийн засгийн үзүүлэлтүүд:

	2005	2006	2007	2008	2009	2010	2011*
Бодлогын үзүүлэлтүүд							
ДНБ-ий бодит өсөлт /хувь/	7.2	8.6	10.2	8.9	-1.3	6.4	17.3
Хөдөө аж ахуй	11.1	6.5	14.4	4.7	3.6	-16.6	0.3
Үйлдвэр	5.5	6.3	7	-0.8	-0.4	4.3	10.1
Үйлчилгээ	9.1	7.6	11.9	16.6	0.8	9.8	17.1
Нэг хүнд ногдох ДНБ /мян. төгрөгөөр/	1091	1561.9	1895.5	2465.1	2432.3	3050.6	3857.4
Нэг хүнд ногдох ДНБ /ам.доллараар/	905.1	1324.2	1619.5	2108.3	1688.2	2264.4	3048.1
Хэрэглээний үнийн өөрчлөлт, оны эцэст	9.5	6.2	17.8	22.1	4.2	13.0	10.2
Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн	837.9	1360.4	1880.5	2170.4	1993.0	3122.5	4159.6
Үүнээс: Урсгал орлого	832.6	1354.1	1856	2151.0	1965.5	3078.3	4141.3
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	764.6	1237	1747.3	2466.8	2321.6	3080.7	4792.0
Үүнээс: Урсгал зарлага	600.3	982.3	1367.7	1761.2	1792.1	2256.3	3234.4
Урсгал тэнцэл	232.3	371.7	488.3	389.9	173.4	822.0	906.9
Нийт тэнцэл	73.3	123.4	133.2	-296.4	-328.6	41.8	-632.4
Төсөв, ДНБ-д эзлэх хувь							
Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн	30.1	36.6	40.9	36.1	32.9	37.1	38.4
Урсгал орлого	30	36.4	40.4	35.7	32.5	36.6	38.2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	27.5	33.3	38	41.0	38.3	36.6	44.2
Үүнээс: Урсгал зарлага	21.6	26.4	29.7	29.3	29.6	26.8	29.9
Урсгал тэнцэл	8.4	10	10.6	6.5	2.9	9.8	8.4
Нийт тэнцэл	2.6	3.3	2.9	-4.9	-5.4	0.5	-5.8
Гадаад худалдааны тэнцэл /сая ам.доллараар/	-113.4	107	-114.3	-710.0	-252.3	-291.6	-1746.5
ДНБ-д эзлэх хувь	-4.9	3.1	-2.7	-12.7	-5.5	-4.7	-20.4
Экспорт	1063.9	1542	1947.5	2534.5	1902.5	2908.5	4780.4
өсөлт, хувь	22.3	44.9	26.3	30.1	-25.6	52.9	64.4
Импорт	1177.3	1435	2061.8	3244.6	2131.3	3200.1	6526.9
өсөлт, хувь	15.5	21.9	43.7	57.4	-34.1	50.1	104.0
Гадаад валютын цэвэр	298	687.6	972.4	637.2	1145.3	2091.2	2273.9

нөөц (сая ам.доллараар)

импортын 7 хоногоор	13.2	24.9	24.5	10.2	27.9	34.0	18.1
Суурь үзүүлэлтүүд							
ДНБ 2005 оны зэрэгцүүлэх үнээр, /тэрбум.төгрөгөөр/	2779.6	3301.6	3640	3964.0	3913.7	4162.8	4881.4
ДНБ оны үнээр, /тэрбум.төгрөгөөр/	2779.6	4027.6	4956.6	6555.6	6590.6	8414.5	10829.7
Хүн амын дундаж тоо, /мян. хүнээр/	2547.8	2578.6	2615	2659.3	2709.7	2758.3	2807.5
Ажилгүйдлийн түвшин /хувь/	3.3	3.2	2.8	2.8	11.6	9.9	7.1
Ам.долларын жилийн дундаж ханш	1205.3	1179.5	1170.4	1169.3	1440.8	1347.2	1265.5
ДНБ /сая ам.доллараар/	2306.1	3414.6	4235	5606.6	4574.4	6245.8	8557.6

*- хүлээгдэж буй гүйцэтгэл

Эх сурвалж: ҮХШХ, 2012 он

Өнгөрсөн 10 жилд Монгол улсын эдийн засгийн өсөлт нэлээд өндөр байсан хэдий ч хүрээгээ огцом тэлж буй жижиг эдийн засаг хэвээр байна. Хамгийн багаар тооцож үзэхэд, Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) ирэх 5 жилд дунджаар жил бүр 13 хувиар өсөх төлөвтэй байна. Гэхдээ ийм хэмжээний өндөр өсөлт гарах эсэх нь дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын үнэ ирээдүйд ямар байхаас хамаарна.

Ашигт малтмалын өнөөдрийн үнэ өмнө хийгдсэн ДНБ-ий хэмжээг урьдчилан таамагласан тооцоо хийхэд ашигласан суурь үнээс өндөр байгаа. Монгол улс ирэх 5 жилд эдийн засгийн хамгийн өндөр өсөлттэй улс байх болов уу?

Хүснэгт 2: Макро эдийн засгийн 2012-2016 он хүртэлх төсөөлөл

	2012	2013	2014	2015	2016
Бодлогын үзүүлэлтүүд					
ДНБ-ий бодит өсөлт /хувь/	15.2	19.0	16.3	11.2	9.3
Нэг хүнд ногдох ДНБ /мян. төгрөгөөр/	5091.0	6487.2	8038.6	9476.9	9569.8
Нэг хүнд ногдох ДНБ /ам.доллараар/	3903.8	5345.3	6902.4	8226.6	8391.2
Хэрэглээний үнийн өөрчлөлт, оны эцэст	13.1	9.8	10.4	8.3	7.4
Гадаад худалдааны тэнцэл /сая ам.доллараар/	-1053.7	582.3	679.3	749.7	869.6
ДНБ-д эзлэх хувь	-4.9	3.1	-2.7	-12.7	-5.5
Экспорт /сая ам.доллараар/ өсөлт, хувь	6198.2	9098.2	10614.0	11713.4	13587.5
Импорт /сая ам.доллараар/ өсөлт, хувь	29.7	31.8	18.3	18.3	16.0
Импорт /сая ам.доллараар/ өсөлт, хувь	7251.9	8515.9	9934.7	10963.7	12717.9
Импорт /сая ам.доллараар/ өсөлт, хувь	11.1	9.1	17.0	17.0	16.0
Суурь үзүүлэлтүүд					
ДНБ 2005 оны зэрэгцүүлэх үнээр, /тэрбум.төгрөгөөр/	5623.1	6691.6	7779.3	8646.8	9453.5
ДНБ оны үнээр, /тэрбум.төгрөгөөр/	14650.8	19070.4	24143.2	29079.7	29952.1
Хүн амын дундаж тоо, /мян.	2877.8	2939.7	3003.4	3068.5	3129.8

хүнээр/					
Ажилгүйдлийн түвшин /хувь/	6.8	6.1	5.4	4.6	3.8
Ам.долларын жилийн дундаж ханш	1304.1	1213.6	1164.6	1152.0	1140.5
ДНБ /сая ам.доллараар/	11234.2	15713.6	20730.6	25243.2	26263.2

Эх сурвалж: СЯ, “Монгол Улсын эдийн засаг, санхүү төсвийн төлөв байдлын талаарх мэдээлэл”, 2012

Монгол улсын эдийн засгийн тэлэлтийн хөдөлгөгч хүч нь уул уурхайн салбарын өсөлт бөгөөд түүний зэрэгцээ гадаад худалдааны тэнцлийн одоогийн нөхцөл байдал, томоохон хэмжээний хөрөнгө оруулалт машин техник, тоног төхөөрөмж ихээр худалдан авахад хүргэж байгаагийн гол шалтгаан нь мөн л уул уурхайн салбар юм. 2013 оноос эхлэн энэ байдал эсрэгээрээ эргэх бөгөөд экспортын хэмжээ импортоосоо давах болно. ДНБ-ий 22 хувийг эзэлж буй уул уурхайн салбарын жилийн өсөлт 2010 он гэхэд 40 хувьд хүрээд байна. Хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх хувийн жин 21 хувь байгаа бөгөөд Монгол улсын эдийн засгийн хоёр дахь том салбарт тооцогдож байна.

2013 оноос Төсвийн тогтвортой байдлын тухай хууль мөрдөгдөж эхлэх бөгөөд энэ нь Засгийн газрын зардал, зээл авалтыг хязгаарлаж өгөх юм. Энэхүү нөхцөл байдал нь уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт, тухайлбал Оюу толгойн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалттай холбоотой байсан зэрэг мөнгөний урсгалыг Монголбанк (МБ)-наас удирдахад илүү хялбар болох юм

2.2. Нийгмийн салбарын үзүүлэлт

Эдийн засгийн өсөлттэй зэрэгцээд Монгол улсын нийгмийн хөгжил мөн хурдацтай байх төлөвтэй байна. Өргөн утгаар нь авч үзвэл, нийгмийн даатгалын сангаас түр хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр насны тэтгэвэр авагчид нь эрүүл мэндийн үйлчилгээг үнэгүй авах боломжтой байна. Монгол улсын холбогдох хуулийн дагуу зөвхөн хүнд, хортой нөхцөлд ажиллахаас бусад тохиолдолд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил тэгш эрх эдэлдэг. Өнөөгийн байдлаар нийт ажиллах хүчний тал хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна.

Хүснэгт 3: Нийгмийн хөгжлийн үзүүлэлт, Монгол улс 1990-2006

Үзүүлэлт	Тоон илэрхийлэл /2011 он/	Гүйцэтгэл /2010 онтой харьцуулахад/	Тайлбар
Амьд төрөлт	70,576	+7.1%	Өнгөрсөн жилтэй харьцуулахад 87 –аар нэмэгдсэн
Нялхсын эндэгдэл	1,152	-9.6%	Өнгөрсөн жилтэй харьцуулахад 123 –аар буурсан
5-аас доош насны хүүхдийн эндэгдэл	258	-25.6%	Өнгөрсөн жилтэй харьцуулахад 89 –өөр буурсан
Нийгмийн даатгалд хамрагдагсдын тоо	653,500	+13.5	Өнгөрсөн жилтэй харьцуулахад 77.6 мянгаар нэмэгдсэн

Нийгмийн сангийн хэмжээ	даатгалын	2.8 тэрбум төг	+22.3%	
Халдварт өвчлөгчдийн тоо	өвчнөөр	42,800	+3.5%	Өнгөрсөн жилтэй харьцуулахад 1,466 –аар нэмэгдсэн
Бүртгэгдсэн хэрэг	эрүүгийн	19,197	-3.2%	Өнгөрсөн жилтэй харьцуулахад 628–аар буурсан

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн товхимол, 2011 оны 6 сар

Сүүлийн жилүүдэд бичил санхүүгийн зах зээл дэлхийн хэмжээнд нэлээд далайцтай хөгжиж ирсэн. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, шинэ технологи бий болгох, хөгжүүлэх, үйлдвэрлэх, бичил болон том бизнесийн хоорондын холбоог бэхжүүлэх замаар ажлын шинэ байр бий болгох явдал чухал байдаг. Бичил санхүүгийн салбарыг хөгжүүлэх нь бичил санхүүгийн системийн тухай олон нийтийн боловсролын түвшин, мэдлэг, ойлголт хэр байгаагаас ихээхэн хамаардаг.

Манай улсын тухайд нийт иргэдийн 40 хувь эдгээр асуудлын талаар мэдлэг мэдээлэл муутай байгаа нь төр, засаг, төрийн бус байгууллага, мөн банк, санхүүгийн байгууллагын зүгээс хууль эрх зүйн үндсийг сайжруулж боловсронгуй болгох, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн өргөн далайцтай арга хэмжээ авах шаардлагатайг харуулж өгч байна.

Хүснэгт 4 : Хүний хөгжлийн үзүүлэлт, Монгол, 1995 – 2010

Үзүүлэлт	1995	1998	2004	2006	2008	2010
Жини индекс	33	30.4	33	33.2	37	NA
Дундаж наслалт	63.8	65.1	64.6	65.9	67.23	68.05
Боловсролын индекс ¹	0.84	0.85	0.91	0.916	0.936	0.943
Хүний хөгжлийн индекс ²	9	2	2	0.63	0.65	0.69
	0.63	0.65	0.69	0.718	0.707	0.703
Бичиг үсэг тайлагдсан байдал (15 наснаас дээш хүн ам), хувиар %	5	1	2	98.9	96.5	97.8
	98.9	96.5	97.8	97.8	97	98

Эх сурвалж: ҮСХ, Статистикийн товхимол, 2011 оны 6 сар

2.3. Монгол улсын улс төрийн орчин, нөхцөл байдал

Монгол улс ардчилсан улс төрийн тогтолцоог бүрдүүлэх, төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийг нэгэн зэрэг хийснээрээ Азийн бусад улс орнуудад үлгэр жишээ үзүүлсэн орон. Монгол улс нь засаглалын нэлээд олон үзүүлэлтээр дэлхийд дээгүүрт, улс төр, эдийн засгийн тогтвортой байдлын үзүүлэлтээр дэлхийн дунджаас дээгүүр байранд тус тус ордог.

Дэлхийн банкны тооцоолсноор олон нийтийн дуу хоолой, хариуцлага, хуулийн хэрэгжилт зэрэг үзүүлэлтээр дэлхийн дунджаас дээгүүрт, төр, засгийн үйл ажиллагааны үр ашиг, төр, засгийн зохицуулах үйл ажиллагааны чанар, авилгыг хянах хяналт зэрэг

¹ Боловсролын индекс нь бичиг үсэг тайлагдсан байдал (2/3-аар жинлэсэн), бага, дунд болон мэргэжлийн боловсролын байгууллагад элсэгчдийн харьцаа (2/3-аар жинлэсэн). Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдсан байдал нь уншиж, бичиж чадах чадварыг харуулсан үзүүлэлт бол GER нь хүүхдийн цэцэрлэгээс дипломын дараахи боловсролын түвшинг илэрхийлсэн үзүүлэлт.

² Хүний хөгжлийн индекс (ХХИ) нь бие махбодь, биологи, сэтгэл мэдрэл, сэтгэл хөдлөл, нийгэм, боловсрол, эдийн засаг, соёлын үзүүлэлтээс бүрддэг. Гэхдээ эдгээрээс зөвхөн зарим нь ХХИ хэлбэрээр илэрхийлэгддэг. Үүнд: Дундаж наслалт, насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдсан байдал, сургуульд сурсан дундаж жил, нэг хүнд ногдох ДНБ. Олон тооны нарийн төвөгтэй үзүүлэлтүүдийг хэмжихэд учирдагтай адил энэхүү индексийг гаргахад мөн л тийм хүндрэл гардаг. Тийм ч учраас нягт нямбай үзүүлэлт гэж үзэхэд хүнд боловч энэ индекс хүн амын сайн сайхан амьдралын түвшинг харьцуулахад хэрэглэдэг маш чухал үзүүлэлт.

үзүүлэлтээр дэлхийн дундаж түвшинд байна. Мөн “Эрх чөлөөний хаус” хэмээх улс төрийн эрх чөлөө, иргэний эрх ямбыг харьцуулан судалдаг тойм судалгааны дүн Монгол улсыг “чөлөөт” гэсэн ангилалд багтаажээ.

2.4. Санхүүгийн зах зээлийн бүтэц

Доорхи хүснэгтээс Монгол улсын санхүүгийн зах зээлийн бүтэц 2008-2011 онд ямар байсныг харж болно.




Хүснэгт 5 : Санхүүгийн зах зээлийн бүтэц, 2008-2011

Үзүүлэлт	2008 он			2009 он			2010 он			2011 он		
	Тоо	Актив (тэрбум төг)	Нийт активт эзлэх хувь	Тоо	Актив (тэрбум төг)	Нийт активт эзлэх хувь	Тоо	Актив (тэрбум төг)	Нийт активт эзлэх хувь	Тоо	Актив (тэрбум төг)	Нийт активт эзлэх хувь
Арилжааны банк	16	3,527	95.7	15	4,215	95.6	14	5,188	95.4			
- Хувийн	16	3,527	95.7	14	4,078	92.5	13	5,007	92.1			
Дотоодын	11	2,291	62.2	9	2,534	57.5	9	3,462	63.7			
Гадаадын (50-иас дээш гадаадын хувийн хөрөнгө оруулалттай)	5	1,235	33.5	5	1,544	35.0	4	1,545	28.4	14	9,222	95.8
- Төрийн өмчийн	0	0	0.0	1	137	3.1	1	181	3.3	13	8,990	93.4
										10	6,612	68.7
										3	2,378	24.7
										1	231.9	2.4
Банк-бус санхүүгийн байгууллага	403	159	4.3	459	196	4.4	430	249.4	4.6	466	404.6	4.2
- Даатгалын компани	16	34	0.9	18	41	0.9	17	46	0.8	17	81.2	0.8
Амьдралын даатгал	1	1	0.0	1	1	0.0	1	1	0.0	1	3.5	0.0
Амьдралын бус даатгал	15	33	0.9	17	40	0.9	16	45	0.8	16	77.7	0.8
-Хадгаламж зээлийн хоршоо	209	32	0.9	212	45	1.0	179	48.8	0.9	162	61.9	0.6
- ББСБ	132	79	2.1	177	97	2.2	182	122	2.2	195	205.4	2.1
- Үнэт цаасны компани/Брокерын пүүс	46	14	0.4	48	13	0.3	52	32.6	0.6	92	56.1	0.6
Санхүүгийн байгууллагын нийт дүн	419	3,685	100.0	474	4,411	100.0	444	5,437.4	100.0	480	9,570.5	100.0

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо
1/ Анод болон Зоос банк ороогүй.

2.5. Банкны салбар

Монгол улсад одоогийн байдлаар 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн долоо нь гадаадын хөрөнгө оруулалттай байгаагаас гурав нь гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, дотоодын хувийн хөрөнгө оруулалттай зургаа, нэг нь төрийн өмчийн банк байна.



2006-2009 онд нийт актив нь жилд дунджаар 30 хувиар өсч байсан банкны салбарын өсөлт илүү хурдасч 2011 оныг 2007 онтой харьцуулахад банкны салбарын нийт активын ДНБ-д харьцуулсан харьцаа 7 нэгжээр нэмэгдсэн.



Эх сурвалж: Олон улсын санхүүгийн статистик

1990-ээд оны сүүл үеийн санхүүгийн хямралын ид үед төрийн өмчийн хоёр банкны удирдлагын эрх мэдлийг бүрэн эрхт төлөөлөгчид шилжүүлсэн бөгөөд банкны салбар нэлэнхүйдээ туйлын эмзэг болж ирсэн. Хямралыг хөнгөхөн даван туулах зорилгоор Засгийн газар эдгээр банкны дийлэнх хадгаламжид баталгаа гаргасан. Эдүгээ эдийн засгийн банкны салбарт үзүүлэх дарамт шахалт хөнгөрсөн хэдий ч олон тооны хүндрэл бэрхшээл оршсон хэвээр.

Капиталын чанарыг үнэлэх асуудал хүнд зорилт байдагчлан банкууд ихэнхдээ өөрийн өмчлөгч компаниудад зээл олгох хэлбэрээр эргэх холбоо бүхий хүндрэл бэрхшээлтэй тулгарч иржээ. Түүнчлэн ихэнх банкууд зээлийн эрсдэл, эрсдэлээс хамгаалагдаагүй гадаад валютын зээлээс үүдэлтэй ханшны хэлбэлзэл (нийт хадгаламжийн дөрөвний гурав нь гадаад валютын хадгаламж) зэргээс шалтгаалан эмзэг байдалд орж байна. Зээлийн өрийн үлдэгдлийг нийт хадгаламжид харьцуулсан харьцаа 82 хувьд хүрч, 2010 оны 9 дүгээр сарын байдлаар эргэн төлөгдөх найдваргүй зээлийн хэмжээ нийт багцын 8 хувьд хүрсэн байв. Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийн хэмжээ өнөөгийн байдлаар 9 хувь бөгөөд үүнийг инфляцийг удирдан залах арга хэрэгсэл болгон ашиглаж байна.

Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ) 2011 оны 5 дугаар сарын 20-нд Засгийн газрын томоохон төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор байгуулагдсан. Засгийн газар бонд гаргах замаар уг банкинд санхүүжилтийн эх үүсвэр олж өгөх тул ам.долларын бонд ирээдүйд гаргана гэсэн үг. Дунд хугацаанд анхаарал хандуулбал зохих асуудлын нэг нь бондыг Засгийн газар баталгаажуулах тохиолдолд эдгээр нь төсвийн эх үүсвэрт тусгагдах ёстой тул Хөгжлийн банк төсвийн зардлын тогтсон эрх зүйн нормыг төөрөгдүүлж болохтой холбоотой асуудал юм. Энэхүү эрсдэлийг давж гарахын тулд МУХБ-ны үйл ажиллагаанд ягштал мөрдөгдвөл зохих багц дүрэм, журамтай байх шаардлагатай бөгөөд үйл ажиллагааг нь нягт хянан шалгадаг байх ёстой. Энэхүү төсөл хөгжлийнхөө дөнгөж эхний шатанд яваа тул амжилт олох эсэх нь эрх бүхий байгууллагуудын Монголын хөрөнгийн зах зээлийг цаашид хөгжүүлж, сайжруулах чадамж, чадвараас ихээхэн хамаарна.

СЗХ, МБ санхүүгийн салбарыг хянан зохицуулах үүрэг хүлээдэг. Гэхдээ хууль тогтоомжийн хэрэгжилтэд түлхүү анхаарч, ирээдүйд гарч болох эрсдлийн түвшинг үнэлж

цэгнэхэд төдийлөн анхаарал хандуулахгүй явж иржээ. Зохицуулалтын шинэ эрх зүйн орчин мөрдөгдөж эхэлснээр Монголбанкны хяналт шалгалт сайжирч байгаа юм. Эдийн засаг үргэлжлэн өсөх хэрээр банкны салбар багцаа төрөлжүүлэх, эрсдлээс хамгаалах болон хөрөнгөө нэмэгдүүлэх илүү боломжтой болно.

Банкны тухай хуульд 2010 онд оруулсан өөрчлөлтийн дагуу СЗХ санхүүгийн салбарт нэгдсэн зохицуулалт хийх дүрэм, журмыг Монголбанкт хамтран боловсруулж мөрдөх шаардлагатай байгаа. Түүнчлэн СЗХ Санхүүгийн мэдээллийн албатай мөнгө угаах, алан хядах үйл ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг санал санаачлагын тухай асуудлаар нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

2.6. Банкнаас бусад санхүүгийн салбар


2.6.1. Үнэт цаасны салбар:

Зах зээлийн үнэлгээ 2011 оны байдлаар 2,168.6 тэрбум /2 их наяд 168 тэрбум 569 сая 984 мянга 199/ төгрөгт хүрсэн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 794.6 тэрбум төгрөгөөр буюу 57.8 хувиар өссөн үзүүлэлтэй байв.

Энэ үзүүлэлт 2006 оноос тасралтгүй өсөж байгаа бөгөөд үүнд уул уурхайн салбарын томоохон компаниудын хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргасан нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг дотоодын хөрөнгийн зах зээл рүү татаж, нэгж үнэт цаасны үнэд эерэг нөлөөлснөөр тэдгээрийн зах зээлийн үнэлгээ өссөнтэй холбоотой гэж үзэж байна.

2011 оны жилийн эцсийн байдлаар хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компанид Таван толгой ХК /579.3 тэрбум/, АПУ ХК /312 тэрбум/, Багануур ХК /274.8 тэрбум/, Шивээ овоо ХК /205.3 тэрбум/, Шарын гол ХК /96.7 тэрбум/ зэрэг хувьцаат компаниуд орж байна.


Зах зээлийн үнэлгээ (тэрбум.төг)



Хөрөнгийн зах зээлийн ерөнхий хандлагыг илэрхийлж буй ТОП-20 индекс 2011 оны жилийн эцсийн дүнгээр 21,687.57 нэгж болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,927.76 нэгжээр буюу 46.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 32954.97 нэгж, доод үзүүлэлт 14686.64 нэгж, дундаж үзүүлэлт 21420.81 нэгж байна.

ТОП-20 индекс сүүлийн жилүүд тасралтгүй өсч байгаа бөгөөд үүний шалтгааныг ТОП-20 индексийн сагсан байгаа компаниудын зах зээлийн үнэлгээ өссөн, мөн хувьцаат компаниудын нэгж хувьцааны үнэ, ханш өссөн, макро эдийн засгийн өсөлт зэрэг хүчин зүйлүүдээс хамаарсан гэж үзэж байна.


ТОП-20 индекс



2011 онд Монголын хөрөнгийн бирж дээр нийт 252 өдрийн арилжаагаар 148 компанийн 122.8 сая ширхэг хувьцааг 109.1 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын 2.4 сая ширхэг бондыг 236.7 тэрбум төгрөгөөр, компанийн 439.5 мянган ширхэг бондыг 4.4 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалагджээ.

Нийт 350.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 125.6 сая ширхэг үнэт цаасыг арилжаалсан байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 257.4 тэрбум төгрөгөөр буюу 3.8 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2006 оноос хойших арилжааны дүнг авч үзвэл дараах байдалтай байна.


Арилжааны дүн (тэрбум төгрөг)



2005 оноос 2010 оны хооронд нийт 16 компани СЗХ-нд үнэт цаасаа бүртгүүлэн IPO, SPO хийгээд байгаа бөгөөд нийт 83.3 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн нь арилжааны нийт дүнд 31.8 хувийг эзэлж байна.

Дээрх IPO, SPO хийсэн компаниудыг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл боловсруулах салбарын аж ахуй нэгжүүд 50 хувийг эзэлж байгаа нь энэ салбарын аж ахуй нэгжүүд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгож түүгээрээ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн боломжтойг харуулж байна.

**IPO, SPO хийсэн компанийг үйл ажиллагааны чиглэлээр
авч үзвэл:**



2011 оны жилийн эцсийн байдлаар мэргэжлийн оролцогч байгууллагуудын актив, пассивын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна:

Хүснэгт 6: Мэргэжлийн оролцогч байгууллагын балансын хураангуй нэгтгэл

Мэргэжлийн оролцогч байгууллагын балансын хураангуй нэгтгэл	2011	2010	өөрчлөлт
Хөрөнгө	67.6	32.6	35.0
Эргэлтийн хөрөнгө	54.7	26.0	28.7
Мөнгөн хөрөнгө	29.9	16.8	13.1
Богино хугацаат хөрөнгө оруулалт	13.5	5.6	7.9
Авлага	7.0	1.7	5.3
Бараа материал	0.2	0.1	0.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4.1	0.3	3.8
Бусад	0.0	1.5	(1.5)
Эргэлтийн бус хөрөнгө	12.9	6.6	6.3
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	67.6	32.6	35.0
Өр төлбөр	28.4	14.7	13.8
Богино хугацаат өр төлбөр	27.4	14.5	12.8
Урт хугацаат өр төлбөр	1.0	0.1	0.9
Эзэмшигчдийн өмч	39.2	18.0	21.2
Өмч: Төрийн өмч	2.3	2.3	-
Хувийн өмч	22.3	10.2	12.1
Халаасны хувьцаа	-	-	-
Хувьцаат капиталын дүн	24.6	12.6	12.1
Нэмж төлөгдсөн капитал	3.7	3.0	0.7
Дахин үнэлгээний нөөц	1.4	0.1	1.3
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	5.7	0.5	5.2
Үнэт цаасны хэрэгжээгүй олз, гарз	2.2	1.9	0.3
Эрсдлийн сан	0.3	0.2	0.1
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1.3	(0.3)	1.6
Тайлангийн үеийн	2.7	1.1	1.6
Өмнөх үеийн	(1.4)	(1.4)	0.0
Үүнээс: цөөнхийн хувь оролцоо	514.0	-	514.0

2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 80 тусгай зөвшөөрөл эзэмшигч компани санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдсан бөгөөд мэргэжлийн оролцогч байгууллагын нийт активын хэмжээ 2,198.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 2,165.8 тэрбум төгрөгөөр буюу 67.3 дахин өссөн үзүүлэлттэй байв.

Энэ нь 2011 онд хөрөнгийн зах зээлд хандах сонирхол идэвхжиж, СЗХ-оос брокер, дилерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн тоо эрс

нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд хөрөнгийн зах зээлийг арилжааны банкууд сонирхож, тухайн банк өөрөө болон түүний охин компаниуд Банкны тухай хуулийн 6.2.7-д зааснаар харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ эрхлэх болон андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан нь салбарын нийт активын дүнг эрс өсгөх үндсэн шалтгаан болжээ.

Нийт активын дүнд эргэлтийн хөрөнгө 81.0 хувь, эргэлтийн бус хөрөнгийн дүн 19.0 хувийг тус тус эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эргэлтийн хөрөнгийн дүн 82 дахин, эргэлтийн бус хөрөнгийн дүн 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Эргэлтийн хөрөнгийн бүтцийг задалж үзвэл мөнгөн хөрөнгө 54.6%, богино хугацаат хөрөнгө оруулалт 24.7%, авлага 12.8%, бараа материал 7.3%, урьдчилж төлсөн зардал 0.6% -иар тус тус бүрдүүлжээ.


Эргэлтийн бус хөрөнгийг үндсэн хөрөнгө 75.8%, бусад үндсэн хөрөнгө 7.7%, биет бус хөрөнгө 6.5%, бусад хөрөнгө 3%-иар тус тус бүрдүүлж байна.

Эргэлтийн бус хөрөнгийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 6.2 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Цаашид СЗХ-ны зүгээс мэргэжлийн оролцогч байгууллагад зайнаас хяналт тавих чиглэлээр түлхүү ажиллаж мэргэжлийн байгууллагын зохистой харьцааны журам, брокер, дилерийн үйл ажиллагааны журам, мэргэжлийн байгууллагын мэдээллийн сангийн журам, нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн зааврыг боловсруулахаар ажиллаж байна.

Мөн шинэчлэн найруулагдсан Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ зөрчсөн, төлбөрийн чадваргүй болсон компаниудыг бүртгэлээс хасч зах зээлийн үнэлгээ өндөртэй хөрвөх чадвар сайтай хувьцаат компаниудын хувьцааг шинээр болон нэмж гаргах тал дээр ажиллахаар төлөвлөж байгаа болно.

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ (ДНБ-нд эзлэх хувиар)



Эх сурвалж: Дэлхийн биржүүдийн холбоо; Блумберг Л.П.; Дэлхийн эдийн засгийн тойм мэдээллийн сан;

Үнэт цаасны чиглэлээр цаашид анхаарах асуудлууд

1. Үнэт цаасны зах зээлийн салбарын эрх зүйн зохицуулалтыг зах зээлийн хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцүүлэх асуудлыг чухалчилж, салбарын хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлт, зарим хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, зарим шинэ хуулийн төслийг тус тус боловсруулан холбогдох газруудад хүргүүлж байсан хэдий ч өнөөг хүртэл хараахан батлагдаж чадаагүй байсаар байгаа юм. Энэ ажлыг 2012 онд үргэлжлүүлэн хуулиудыг батлуулах талаар чармайлт гарган ажиллана. Энэхүү хуулиуд батлагдсанаар үнэт цаасны зах зээлийн хөгжилд чухал алхам болох бөгөөд улмаар олон улсын байгууллагууд, гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий зохицуулалтын байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага, мэдээлэл солилцох зэрэгт чухал ач холбогдолтой.

а/ “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг Хууль зүй дотоод хэргийн яам, Сангийн яамнаас томилогдсон мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, уг хуулийн төслийг эцэслэн боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаас уг төслийг дэмжиж Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн. Энэ хуулийг батлуулах, улмаар салбарлан гарах дүрэм журмыг шуурхай баталж эрх зүйн цогц орчныг бүрдүүлэх нь чухал зорилтын нэг болно.

б/ Хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын эрх зүйн статусыг тодорхой болгох, тэдгээрт тавих шаардлага, үйл ажиллагааны зарчмыг тодорхой болгох, гадаадын хөрөнгө оруулалтын байгууллага Монголд үйл ажиллагаа явуулах асуудлыг хуульчлах чиглэлээр “Хөрөнгө оруулалтын сангийн тухай” хуулийн төсөл боловсруулсан байсан хэдий ч уг төслийг сайжруулах боловсронгуй болгохоор дахин ажиллаж байна.

в/ Шинээр батлагдсан Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна.


2. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг олон улсын нийтлэг жишгийн дагуу зохион байгуулах, хөрөнгийн бирж, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын техник, технологийг олон улсын жишигт хүргэх, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбох, төлбөр тооцоог банкны системд тулгуурлан шуурхай хэрэгжүүлдэг байх нөхцлийг бүрдүүлэх зэрэг дэд бүтэц, зохицуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үргэлжлүүлэн улам чанартай, үр дүнтэйгээр зохион байгуулна. Засгийн газраас Лондонгийн Хөрөнгийн биржтэй байгуулсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, ялангуяа Монголын хөрөнгийн биржийг хөгжүүлэх Мастер гэрээг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах нь чухал зорилтуудын нэг болно.

3. Хөрөнгийн зах зээлийн талаарх бүх нийтийн боловсролын түвшинг дээшлүүлэх нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, орон нутагт шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах таниулах ажлыг үе шаттайгаар орон даяар зохион байгуулна.

2.6.2. Даатгалын салбар:

Даатгалын зах зээлийн үзүүлэлтүүд

Даатгалын байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад 2010 онд 38 хувиар, 2011 онд 43,2 хувиар тус тус өсч, 2011 оны 4 дүгээр улиралд 81.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.




Тус салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2011 оны байдлаар 48 тэрбум төгрөг болж 2010 оноос 1,5 дахин нэмэгдсэн, даатгалын компаниудын 2011 оны цэвэр ашиг 10.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 3 дахин өссөн нь даатгалын байгууллагуудын санхүүгийн чадавхи бэхжиж, цаашид даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүд сайжрах төлөвтэй байгааг илтгэн харуулж байна.




Даатгалын салбарын хэмжээнд тайлант хугацаанд даатгалын компаниудын олсон нийт орлого ихээхэн өссөн дүнтэй гарсан нь нэг талаас даатгалын зах зээлийн хамралт нэмэгдэж тэлсэн, нөгөө талаас даатгалын үнэлгээ болон үнийн ерөнхий өсөлттэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Даатгалын нийт хураамжийн орлогын хэмжээг ДНБ-ий 2011 оны урьдчилж тооцоолсон дүнтэй харьцуулахад өмнөх оны мөн үеийнхээс 0,06 пунктээр нэмэгдэн 0,44% болсон байна.



2011 онд даатгалын нөхөн төлбөр 10.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 3.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Даатгалын нөхөн төлбөрийн дүн 2004 онд буурч байсан бол 2006 оноос хойш тогтмол өссөн үзүүлэлттэй байна.



Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн. 2007 оны байдлаар даатгалын нөөц сангийн хэмжээ 17.6 тэрбум төгрөг байсан бол 2011 оны эцэст 36.1 тэрбум төгрөгт хүрч 5 жилийн өмнөх мөн үеийнхээс 18.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Даатгалын зуучлагч

СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөл бүхий даатгалын зуучлагч 8 компани үйл ажиллагаа явуулж байна.

2011 онд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 314.0 сая төгрөг, үүнээс 89,1 хувь буюу 280.0 сая төгрөгийг даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого эзэлж байна.

Даатгалын хохирол үнэлэгч

СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөл бүхий 9 даатгалын хохирол үнэлэгч компани зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байна.

2011 онд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 154.4 сая төгрөг болсон байна. Үүнээс даатгалын хохирол үнэлэгчийн орлого нийт орлогын 17,5 хувь буюу 27.1 сая төгрөг болж, үлдсэн 82,5 хувийг бусад орлого эзэлж байна.

Даатгалын салбарын хөгжлийн динамик үзүүлэлтүүдийг сүүлийн жилүүдийн байдлаар нэгтгэж үзэхэд даатгалын зах зээл эрчимтэй хөгжиж, тус салбарын нийт эдийн засагт эзлэх хувь хэмжээ, гүйцэтгэх үүрэг роль жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Даатгалын чиглэлээр цаашид анхаарах асуудлууд

Цаашид даатгалын салбарт дараахь асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна:

1. Гадаадын даатгагчид шууд даатгуулах үйл ажиллагааг журамлаж, гадаадын хөрөнгө оруулалттай болон Монгол улсын томоохон аж ахуйн нэгжүүдийг дотоодын даатгалд хамруулах нөгөө талаас Монгол улсын нутаг дэвсгэрт даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын даатгалын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох шаардлагатай байна. Энэ нь манай дотоодын даатгагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлж, манай улсад татвар төлөхгүй байх нөхцөл бололцоог бүрдүүлж байна.

2. 2011 оны байдлаар даатгалын компаниуд гадаадын давхар даатгагч нарт их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж, 10.7 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,4 дахин өссөн. Иймд үндэсний давхар даатгалын компани байгуулах шаардлагатай байна.

3. Урт хугацаат даатгалыг нийгмийн даатгал, ЭМД-тай уялдуулах, Тэтгэврийн даатгалын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, хяналт, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4. Жолоочийн албан журмын даатгалыг хэрэгжүүлэх асуудал өнөөдрийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Үүнээс гадна олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын заавал даатгал, өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа явуулдаг зарим аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын даатгалыг ч мөн судлах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

5. Бусад: Интернет даатгалын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг сайжруулах, Банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох зохицуулалт, хяналтын орчинг сайжруулах, тавигдах зарчим стандартыг судалж, хэрэгжүүлэх, Даатгалын сангуудын чөлөөт хөрөнгийг хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах боломжийг бий болгох, Даатгалын зах зээлийн хөгжих гол нөхцөл болох даатгалын бүтээгдэхүүнийг боловсронгуй болгох, Даатгалын мэргэшлийн боловсон хүчний чадавхийг сайжруулах, Даатгалын олон улсын стандартуудыг нэвтрүүлэх /IFRS-4, Solvency -2, бусад/ гэх мэт.

2.6.3. Банк бус санхүүгийн байгууллага

ББСБ-ын салбарын үйл ажиллагаанд нэн тааламжтай орчинг бий болгох, санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэн хөгжүүлж, эрх зүйн боломж, бололцоог бүрдүүлэх, санхүүгийн салбарын хөгжлийн чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлэх, зохицуулалтын уян хатан бодлого баримтлах зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулсан хуулийн төслийг СЗХ-оос боловсруулан УИХ-ын гишүүдэд хүргүүлээд байна. Хуулийн төсөл батлагдсанаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын зохицуулалтын эрх зүйн орчин тодорхой болж, тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжих, санхүүгийн зуучлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэхийг зохицуулалтын бодлогоор дэмжих, түүнд тавигдах шаардлага, хориглох зүйл болон хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомж зөрчигчдөд авах албадлагын арга хэмжээ, ногдуулах захиргааны шийтгэлийн хэмжээг бодитой тогтоосноор тухайн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулж, цаашдын тогтвортой хөгжилд ач холбогдолтой арга хэмжээ болох юм.


Үүний дүнд санхүүгийн зах зээлийн банк бус санхүүгийн салбарыг хөгжүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болж, үйл ажиллагаа эрхлэх таатай орчинг бүрдүүлсэнээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, салбарын хөгжлийн эрчимжилтийг бататгах, төрөөс баримталж буй мөнгөний бодлогыг зөв зүйтэй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний нөлөө үзүүлж, улмаар нийгэм, эдийн засагт ББСБ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх юм.

СЗХ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2006 оноос хойш дангаараа болон Монголбанкт хамтран баталсан нийт нэр бүхий 22 журам, заавар, аргачлал хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

ББСБ нь улс орны өнөөгийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал, хууль эрх зүйн орчин, уламжлал зэргээс шалтгаалж бусдаас хадгаламж татан төвлөрүүлдэггүй, хөрөнгийн гол эх үүсвэр нь хувь нийлүүлэгчдээс оруулсан мөнгөн хөрөнгө байдаг тул үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэл багатай, ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулж байгаа, банкнаас үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жижиг, дунд зээлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлдэг,


бизнес эрхлэгчдийн бичил, жижиг, дунд зээлийн гэнэтийн хэрэгцээг шуурхай хангах бололцоотой, зээлдэгчдийн эрхлэх бизнесийн эрсдэлээс шалтгаалж зээлийн хүүг харилцан тохиролцож болдог буюу зээлийн хүүгийн хэмжээ уян хатан байдаг зэрэг өөрийн гэсэн онцлог шинж, давуу талуудтай байгууллага юм.

Монгол улсын санхүүгийн салбарт гарсан дэвшилтэт өөрчлөлтүүдийн нэг нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд банкны зарим үйл ажиллагааг хүргэх, тэр болгон хүрч чаддаггүй бичил зээлийн томоохон орон зайг нөхөх, санхүүгийн зуучлалын хүрээг өргөжүүлэх зорилгоор ББСБ-ууд 1999 оноос эхлэн шинээр үүсч хөгжиж ирсэн явдал юм. ББСБ-ын салбарын актив жил ирэх тутам өсч байсан ба 2011 оны байдлаар ББСБ-ын салбарын нийт активын хэмжээ 2006 оны үзүүлэлтээс 3 дахин, олгосон зээлийн багцын хэмжээ 3.9 дахин тус өссөн байх ба нийт активт эзлэх зээлийн багцын хэмжээ 43.8-57.9 хувь байгаа нь ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа хэвээрээ байгаа болохыг харуулж байна.



Монголбанкны 2005 онд гаргасан дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай шийдвэрийг хангаж ажиллах боломжгүйн улмаас 2007 онд ББСБ-ууд татан буугдсантай холбоотойгоор нийт активын хэмжээ буурч байсан бол СЗХ-оос валют солих цэгийн үйл ажиллагааг төрөөс хянан зохицуулахтай холбогдуулан хууль тогтоомжийн хүрээнд банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан үйл ажиллагаагаа эрхлэхээр зохицуулалт хийсэн, банк бус санхүүгийн байгууллагуудын дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай шийдвэр гаргасан зэрэгтэй холбогдуулан нийт хөрөнгийн хэмжээ жил ирэх тутамд нэмэгдсээр ирсэн ба 2011 оны байдлаар ББСБ-уудын нийт актив нь банкны салбарын нийт активын 2.2 хувийг эзэлж байна.

Зээлийн чанарын хувьд 2006-2011 онуудад нийт зээлийн багцын 1.3-6.1 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй байна.




Дээрх онуудын үзүүлэлтийн дунджаар тооцвол нийт зээлийн багц дахь 90.6 хувийг хэвийн, 3.7 хувийг хугацаа хэтэрсэн, 5.7 хувийг чанаргүй зээл эзэлж байна.


Нийт эх үүсвэрийн бүтцийн хувьд сүүлийн 6 жилийн байдлаар 69.0-77.6 хувийг эзэмшигчдийн өмч, 22.4-31.0 хувийг нийт өр төлбөр эзэлж байна. 2011 оны байдлаар нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмч 138.2 тэрбумд хүрсэн нь банкны салбарын 20.4 хувийг эзэлж байна.



Нийт өр төлбөр 2006 оноос 2011 оныг хүртэл 3.1 дахин өссөн байх ба 2011 оны байдлаар нийт өр төлбөрийн 77.7 хувийг банк, санхүүгийн байгууллагад төлөх зээл, хувийг итгэлцлийн өглөг, төслийн зээлийн санхүүжилт эзэлж байна. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ын тоо сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор салбарын нийт итгэлцлийн өглөгийн хэмжээ өсөх хандлагатай байна.




Нийт эзэмшигчдийн өмч 2006 оноос 2011 оныг хүртэл 2.9 дахин өссөн байна. 2006 онд хувь нийлүүлэгчдийн оруулсан хувьцаат капиталын хэмжээ 91.2 хувийг эзэлж байсан бол 2011 оны 84.3 хувь болж буурсан байх ба хуримтлагдсан ашиг 4.0 байснаас 10.6 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.



Хувьцаат капиталын хэмжээ 116.5 тэрбумд хүрсэн нь банкны салбарын 44.1 хувийг эзэлж байна. Түүнчлэн хөрөнгө оруулагчдын зүгээс “Базел 2”-д заасан зарчмын дагуу хоёрдогч өглөгөөр мөнгөн хөрөнгө байршуулах замаар эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх байдал мөн л өсөх хандлагатай байна.

2006-2011 онд нийт орлого 5.1, нийт зардал 4.5 хувиар тус тус өссөн бол хуримтлагдсан ашиг 8.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Нийт орлогод эзлэх хуримтлагдсан ашиг 2006 онд 14.3 хувь байгаа нь сүүлийн 6 жилийн хугацааны хамгийн бага үзүүлэлт бол, 2011 онд 24.6 хувьд хүрсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Банк бус санхүүгийн байгууллагын чиглэлээр цаашид анхаарах асуудлууд

СЗХ цаашид тус салбарын талаарх цаашдын бодлогын хувьд дээр дурдсан ББСБ-ын онцлогуудыг анхаарахын зэрэгцээ хувь нийлүүлэгчдээс оруулсан хөрөнгөөс гадна бусдаас татах бусад эх үүсвэр дутагдаж байгаа тал дээр анхаарч ажиллах зайлшгүй шаардлагатай байна.

ББСБ-уудын санхүүгийн зах зээлд эзлэх байр суурь, иргэд, харилцагчдад хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрийн гүйцэтгэх үүргийн хувьд тэдгээрийн үндсэн үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа байгаад анхаарлаа хандуулж, хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа, санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэхэд журам, заавар зэрэг зохицуулалтын баримт

бичгийн хувьд боловсронгуй болгох, арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлэх нь чухал байна.


Мөн ББСБ-уудын үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг оновчтой, уян хатан байлгах, тусгай зөвшөөрөл олгох, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг аль болох хялбарчлах арга замыг эрэлхийлэн ажиллах нь зүйтэй. Түүнчлэн тодорхой үе шаттайгаар СЗХ-ны зарим эрх, үүргийг салбарын мэргэжлийн холбоод руу шилжүүлэх арга хэмжээ авах, эрх зүйн зохицуулалтыг нь бий болгох нь цаашдын зорилтын нэг болж байна.

2.6.4. Хадгаламж, зээлийн хоршоо

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодыг нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдуулан олон улсын хоршооллын зарчмын дагуу хөгжих боллоцгоог бүрдүүлэх, санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, бусад санхүүгийн байгууллагуудтай өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хямралын үед гарсан, нийгмийг хамарсан муу үр дагавар бүхий үйлдлүүдийг дахин гаргахгүй байх зэрэг хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос ялгарах онцлогт тохирсон зохицуулалт бүхий Хадгаламж, зээлийн хоршооны тухай бие даасан хуулийн төслийг СЗХ-оос шинэчлэн боловсруулж, улмаар УИХ-ын 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлагдан, мөн оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдөгдөн хэрэгжиж эхэлсэн.

СЗХ-ны зүгээс тус хуульд нийцүүлэн ХЗХ-ны салбарын үйл ажиллагааг хуульд заасан болон олон улсын зарчимд нийцүүлэн хөгжүүлж, гишүүдэд хүргэх санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд бий болж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, идэвхитэй үйл ажиллагаа, хариуцлагыг сайжруулахтай холбогдуулан журам, заавруудыг шинэчлэх, шинээр батлуулж мөрдүүлэх тал дээр анхаарлаа хандуулан ажиллаж байна.

2011 оны байдлаар СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэйгээр 162 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр хадгаламж, зээлийн хоршоодын 71 буюу 43.8 хувь нь Улаанбаатар хотод, 91 буюу 56.2 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.




Тайлант онууд дахь хадгаламж, зээлийн хоршоодын тооны өөрчлөлттэй холбоотойгоор гишүүдийн тоонд дараах өөрчлөлтүүд орсон байна.




Нийт хөрөнгийн хэмжээ жил ирэх тутамд нэмэгдсэн байх ба 2011 оны байдлаар нийт активын хэмжээ 2006 онохоос 4 дахин өссөн байна. 2011 онд нийт активын 67.0 хувийг гишүүдэд олгосон зээлийн багцын үлдэгдэл, нийт эх үүсвэрийн 70.8 хувийг гишүүдээс татсан хадгаламж, 13.6 хувийг гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 7.8 хувийг хоршоологчдын өмч тус тус эзэлж байна.

ХЗХ-дын нийт актив нь банкны салбарын нийт активын 0.7 хувийг эзэлж байна.




Зээлийн чанарын хувьд 2006-2011 онуудад нийт зээлийн багцын 0.8-2.6 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй байна.



Дээрх онуудын үзүүлэлтийн дунджаар тооцвол нийт зээлийн багц дахь 85.1 хувийг хэвийн, 7.8 хувийг хугацаа хэтэрсэн, 7.1 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна.

2006-2011 онд нийт орлого 2.1, нийт зардал 1.7 хувиар тус тус өссөн бол хуримтлагдсан ашиг 2006 онд 0.2 хувийн алдагдалтай, 2011 онд 2.2 тэрбум төгрөгийн ашигтай байна.



Хуримтлагдсан ашиг сүүлийн 5 жилийн дунджаар нийт орлогын 15.5 хувийг эзэлж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны чиглэлээр цаашид анхаарах асуудлууд

Шинээр батлагдан гарсан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн салбарын үйл ажиллагааг хуульд заасан болон олон улсын зарчимд нийцүүлэн хөгжүүлж, гишүүдэд хүргэх санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд бий болж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, идэвхитэй үйл ажиллагаа, хариуцлагыг сайжруулахтай холбогдуулан журам, заавруудыг шинэчлэх, шинээр батлуулж мөрдүүлэхэд эрчимтэй ажиллах шаардлагатай байна.

Ялангуяа орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх, тэдгээрийн бизнесийн үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийг хангахад орон нутгийн онцлогтой уялдуулан хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих төрөөс баримтлах бодлогын тодорхойлоход Хороо эн тэргүүнд анхаарах нь зүйтэй.

Түүнчлэн шинээр хууль батлагдсантай холбогдуулан 2012-оос 2015 онд хэрэгжүүлэх Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр Азийн хөгжлийн банк, СЗХ-той хамтран хэрэгжүүлж буй “Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд гүйцэтгэх ХЗХ-дын үйл ажиллагаанд өгөх үнэлгээ, дүгнэлт өгч цаашдын хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох, ХЗХ-д болон бусад санхүүгийн байгууллагуудын чадавхи, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлыг үр дүнтэй, чанартай, хүртээмжтэйгээр зохион байгуулах нь СЗХ-ны цаашдын үйл ажиллагааны чухал хэсэг юм.

2.7. Товч дүгнэлт

Эдийн засаг: Ирэх арван жилд хамгийн өндөр өсөлттэй эдийн засаг байх болно (2010-2020).

Хөдөлгөгч хүч буюу гол нөлөөлөх хүчин зүйлүүд: Хөрөнгө оруулалт, экспорт, бүтээгдэх баялаг

Аж үйлдвэр: Уул уурхай, банк, үл хөдлөх хөрөнгө, өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Боломж бололцоо: Бүх хөрөнгө ялангуяа, төрийн болон орон нутгийн өмчийн актив

Орчин: Ардчилал, улс төрийн тогтвортой байдал, бизнесийг хөгжүүлэх бодлого бүхий төр, засаг

Макро эдийн засаг, нийгэм, санхүүгийн үзүүлэлт, улс төрийн орчин нөхцөл, банк болон банкнаас бусад санхүүгийн системийн бүтэц зэргээс харахад зарим эрсдэл (дор үзүүлсэн матрицийг харна уу) оршсоор байх төлөв ажиглагдаж буй тул Монгол улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах үүднээс түүнийг анхаарал болгоомжтой залах хэрэгтэй.

Хүснэгт 7: Ойрын ирээдүй болон дунд хугацааны эмзэг байдлыг харуулсан эрсдэлийн үнэлгээний матриц

Хүндрэл бэрхшээлийн түвшин

Мөн чанар/Гол аюул заналын эх булаг буюу анхдагч учир шалтгаан	Ирэх 3 жилд учирч болзошгүй аюул заналыг хүлээн зөвшөөрөх магадлал	Аюул занал байж болзошгүйг хүлээн зөвшөөрсөнөөр санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх нөлөөлөл
---	--	---

Макро эдийн засгийн эрсдэл Эдийн засаг, экспортын өсөлт зэс олборлолтоос хэт хамааралтай байх учир эдийн засаг зэсийн үнийн өөрчлөлтөөс хамаарсан эмзэг байдалд оршин байна.	Үнэлгээний түвшин: Дунд зэрэг Хэдийгээр фьючерсийн зах зээл эрчим хүчний үнийн өсөлтийг урьдчилан сануулдаг ч зэсийн үнийн хэлбэлзлийг урьдчилан таамаглахад хүнд	Үнэлгээний түвшин: Дунд зэрэг Зэсийн үнэ гэнэт буурах нь санхүүгийн салбарын тогтвортой байдал болон макро эдийн засгийн гүйцэтгэлд сөрөгөөр нөлөөлнө.
Төвлөрлийн эрсдэл Банкны салбарын хувь заяа цөөн тооны томоохон зээлдэгчээс хамаарч байна. Ерөнхийд нь авч үзэхэд, банк бүр 20 орчим тооны (38 байгууллага) томоохон зээлдэгчдэд үйлчилдэг бөгөөд тэдгээрийн авсан зээлийн хэмжээ тухай тухайн банкны нийт зээлийн өрийн үлдэгдлийн 33 хувь, 10 томоохон зээлдэгчийн авсан зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10 хувийг тус тус эзэлж байна.	Үнэлгээний түвшин: Дунд зэрэг Санхүүгийн салбарт удаан хугацаанд оршоор ирсэн өндөр эрсдэл, цөөн тооны томоохон зээлдэгчтэй холбоотой анхаарал хандуулбал зохих асуудлын зэрэгцээ илүү хүндрэл бэрхшээл цаашид ч учрах магадлал бий гэдэгт ач холбогдол өгөхгүй өнгөрөх аргагүй. Санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, эдийн засгийн хүлээгдэж буй өсөлт, цөөн тооны компаниас хараат байгаа явдал эдгээр эрсдэл учрах магадлалыг өсгөж байна.	Үнэлгээний түвшин: дунд зэрэг Том компанийн азгүйтэл банкны системд шууд нөлөөлж, энэ байдал улмаар санхүүгийн салбарын тогтвортой байдалд аюул учруулна. Өндөр эрсдлийн нөлөө дан ганц банкны салбараар зогсохгүй хоорондоо уялдаа холбоотойн улмаас санхүүгийн систем тэр чигээрээ эрсдэлд өртөх аюултай.

Хүндрэл бэрхшээлийн түвшин

<p>Мөн чанар/Гол аюул заналын эх булаг буюу анхдагч учир шалтгаан</p>	<p>Ирэх 3 жилд учирч болзошгүй аюул заналыг хүлээн зөвшөөрөх магадлал</p>	<p>Аюул занал байж болзошгүйг хүлээн зөвшөөрсөнөөр санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх нөлөөлөл</p>
--	---	--

<p>Хүлцэнгүй, өршөөнгүй дүрэм журам Зээлийг хугацаа хэтэрсэнд тооцохын өмнө тухайн зээлийг хоёр дахин хугацааг нь сунгаж болох практик амьдралд хэрэгжиж буй нь активын чанарыг үнэлэхэд хүндрэл учруулж байна.</p>	<p>Үнэлгээний түвшин: Өндөр Хяналт, шалгалтын үйл ажиллагаа хүлцэнгүй, өршөөнгүй дүрэм журам дээр үндэслэн явагддаг. Өөрөөр хэлбэл, тухайн ажилтан өөрийн үзэмжээр шийдвэр гаргах боломжтой байдаг гэсэн үг. Хүчин төгөлдөр дүрэм, журмыг бүх тохиолдолд жигд хэн нэгэнд давуу тал үл олгон мөрдөхгүй бол үр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийг бууруулахад хүргэнэ.</p>	<p>Үнэлгээний түвшин: Өндөр Өөрийн хөрөнгө нь хангалтгүй банкны хяналт, шалгалтын ажил зохистой бус хэлбэрээр үргэлжилсээр аваас тухайн банкинд итгэх Монголбанкны итгэл алдарч, улмаар санхүүгийн тогтворгүй байдал руу хөтөлнө.</p>
<p>Инфляци, банкны хүү, валютын ханшны эрсдэл Мөчлөг дагасан төсвийн бодлого нь инфляци өсөхөд нөлөөлж байна.</p>	<p>Үнэлгээний түвшин: Дунд зэрэг Хүнсний бүтээгдэхүүний үнэ, төрийн албан хаагчдын цалин, тэтгэврийн өсөлт, Оюу толгойн барилга байгууламжаас үүдэлтэй дотоодын эрэлт нэмэгдсэн зэргээс шалтгаалан инфляцийн дарамт их байна. Түүнчлэн төсвийн задгай үрэлгэн бодлого инфляцийн дарамтыг улам нэмэгдүүлж байна.</p>	<p>Үнэлгээний түвшин: Өндөр Байдал хэвээр үргэлжлэх аваас инфляци банкны системийн актив, пассивын бодит үнэ цэнэд нөлөөлж, улмаар салбарын тогтвортой байдалд үлэмж хэмжээний хүндрэл учруулна.</p>

Эх сурвалж: Олн улсын валютын сангийн тайлан - N° 11/107

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

3.1. Бүрэлдэхүүн хэсэг

СЗХ нь ашгийн төлөө бус байгууллага тул Хорооны стратегийн төлөвлөгөөг Үйл ажиллагааны стратеги (Корпорацийн стратеги) хэмээн нэрлэнэ. Энэхүү Үйл ажиллагааны стратеги нь СЗХ-оос санхүүгийн зохицуулагчийн хувьд өөрийн эрхэм зорилгыг ажил хэрэг болгохын тулд сонгож буй зам мөр юм.

Орчин, нөхцөл байдлын шинжилгээ, стратегийн сегментчилал хийсний дараа Үйл ажиллагааны стратегийн үзэл баримтлалыг тэдгээртэй хамтатгах замаар стратегийн бүтэц, бүрэлдэхүүн хэсгийг дараах байдлаар авч үзсэн. Үүнд:

- Алсын хараа/Хэтийн зорилго;
- Эрхэм зорилго;
- Стратегийн зорилго/зорилт;
- Үнэт зүйлс;
- Бизнесийн стратегийг бизнесийн буюу эрхлэх ажлын үйл явцын загвар хэлбэрээр боловсруулсан.

Корпорацийн стратегийн өөр нэгэн хэллэг болох “Бизнесийн стратеги”-ийг СЗХ-ны онцлогт тохируулан авч хэрэглэхийг зорьсон. Бизнесийн гэдэг нэр хэрэглэхээс зайлсхийх үүднээс Үйл ажиллагааны стратегийн хоёр ангилалыг авч хэрэглэхээр шийдсэн. Үүнд:

- Зохицуулах үйл ажиллагааны стратеги;
- Туслах үйл ажиллагааны стратеги.

СЗХ-ны ажилтнуудтай хийсэн уулзалтын үеэр харилцан ярилцаж санал солилцсоны дүнд Хорооны Алсын харааг энэхүү стратегидаа тусгахгүй байхаар шийдсэн. Учир нь Алсын хараа нь төрийн бодлого, стратегийн нэг хэсэг тул Хорооны хяналтаас гадуурх асуудал гэж үзсэн.

3.2. Эрхэм зорилго

Санхүүгийн тогтвортой байдлыг хангахад оруулдаг СЗХ-ны хувь нэмэр нь зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд сайтар хяналт тавьж, санхүүгийн тогтвортой байдалд учирч болзошгүй аюул занал, эрсдлийг олж илрүүлэн зохих арга хэмжээ авахад оршдог.

“СЗХ-ны санхүүгийн тогтвортой байдлыг хангах стратеги”-д дараах агуулгыг багтаасан:

“Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх”

СЗХ-ны үйл ажиллагааг олон улсын стандартад “нийцүүлэх” тухай эрхэм зорилгыг тодорхойлохдоо Монголын зах зээлийн онцлогийг харгалзан үзсэн болно. Тогтвортой хөгжүүлэх/байх гэдэг нь тогтмол түвшинд тогтвортой байх гэдгээс илүү өргөн хүрээний асуудлыг хамардаг. СЗХ олон улсын шинэ стандарт, өөрийн орны онцлог, эдийн засгийн

орчин нөхцлийг харгалзан үзсэний үндсэн дээр урьдчилан сэргийлж чадах бүтцийг зах зээлд бий болгохыг зорьж байна.

Эрхэм зорилготой болох нь үүнтэй ямар нэгэн сэжмээр холбогдох хүмүүс, байгууллагад үнэ цэнэ бий болгодгоороо давуу талтай байдаг. Эрхэм зорилго нь үйл ажиллагааны чиглэл, боломж бололцоог бий болгож өгдөг бөгөөд стратеги тодорхойлох үйл явцын салшгүй чухал хэсэг мөн.

3.3.Стратегийн зорилго

СЗХ нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх, дүрэм журам, шийдвэр гаргах, хяналт тавих, ажиглалт хийх, бодлогын уялдааг хангах, хууль тогтоомжийг мөрдүүлэх замаар тогтвортой хөгжил бүхий санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх /бэхжүүлэх/ зорилготой бөгөөд зохицуулалт хийх үндсэн үүрэг бүхий байгууллага юм.

Иймд, СЗХ-ны үндсэн зорилгыг дараах байдлаар тодорхойлж болно:

- 1. Монгол улсын санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, тогтвортой хөгжлийг бэхжүүлэх;**
- 2. Санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох;**
- 3. Харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах (туслах), хадгаламж эзэмшигчдийн эрхийг хамгаалах (үндсэн);**
- 4. Олон нийтийг сургах, санхүүгийн зах зээлийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах.**

Үйл ажиллагааны стратегийг тодорхойлоход харгалзан үзэх шаардлагатай нэгэн гол зорилго бол стратегид тусгалаа олсон асуудал буюу арга хэмжээ нь амьдралд хэрэгжихүйц байхад оршдог. Ихэнх стратегийн төлөвлөгөө өндөр түвшний санаачлагыг анхааралдаа авсан, хэтийн зорилгоо тодорхойлсон байдаг ч уг санаачлагыг амьдралд хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсөл хэлбэрт ороогүй байдаг. Ийм ч учраас СЗХ-ны эрхэм зорилго стратегийн зорилгод тусгалаа олж, зорилгодоо хүрэх үйл ажиллагааг тусгасан төсөл хэрэгжүүлсэн талаар энэхүү “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги”-ийн баримт бичгийн дараа дараагийн бүлэгт дурдсан байгаа.

3.4.Санхүүгийн Зохицуулах Хорооны үнэт зүйлс

СЗХ-ны үнэт зүйлс, итгэл үнэмшил юу байвал зохих асуудлаар талууд санал нэгдэж чадсан. СЗХ-ны үнэт зүйлс нь байгууллагын соёл, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд хөтлөх бөгөөд түүнээс гаргах аливаа шийдвэрийн үндэс суурь болно. Дор дурдсан үнэт зүйлсийн нэгдэл нь СЗХ-ны зан төлөв, үйл ажиллагааны чиг хандлагаар илэрхийлэгдэнэ. Үүнд:

- Хараат бус байх;
- Итгэл хүлээсэн байх;

- Хүндэтгэл хүлээсэн байх;
- Ил тод байх.

Энэхүү үнэт зүйлсүүд нь СЗХ-ны үйл ажиллагааны үндэс суурь болох бөгөөд өөр хоорондоо хэрхэн уялдах, эрхэм зорилгоо биелүүлэхэд ямар стратегийг ашиглаж болохыг харуулж өгнө.

3.5. Санхүүгийн Зохицуулах Хорооны гүйцэтгэх ажлын урсгалын загвар

Үйл ажиллагааны стратегид хоёр үндсэн асуудал хөндөгдсөн. Үүнд:

- СЗХ өөрийн үндсэн зорилгыг хэрхэн тодорхойлох (Зохицуулах үйл ажиллагааны стратеги) вэ?
- СЗХ өмнөө тавигдсан зорилгыг биелүүлэхийн тулд өөрийн өдөр тутмын дотоодын үйл ажиллагааг хэрхэн удирдан зохицуулах (Туслах чанарын үйл ажиллагааны стратеги) вэ?

Зохицуулах үйл ажиллагааны стратеги нь голчлон харилцагч, хадгаламж эзэмшигч, зохицуулалт бүхий зах зээлийн оролцогчид, мэргэжлийн холбоод гэх мэт зохицуулалтын хүрээнд хамаарах зах зээлд оролцогчдын тухай асуудлыг авч үздэг.

Туслах үйл ажиллагааны стратеги нь зохицуулалт хийх үндсэн үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий байгууллагын дотоод стратеги юм.

Туслах үйл ажиллагааны стратеги нь зохицуулах үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх хамгийн таатай, үр ашигтай орчныг бүрдүүлэхээр боловсруулагдсан байх ёстой байдаг.

Хүснэгт 8 : Эрхэм зорилго, зорилт, үнэт зүйлс хоорондын уялдаа холбоо




СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загварт хэрхэн үнэт зүйлсээ тодорхойлж, мөрдөж, анхааран авч үздэгийн шалтгааныг зураглан үзүүлсэн. Гүйцэтгэх ажлын урсгалын загвар нь үйл ажиллагааны стратегийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

СЗХ-ны ажилтнуудын ур чадвар, чадавхи, үр дүнтэй хөдөлмөрийн бүтээмж, оновчтой зохицуулалтын үйл ажиллагаа нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд маш

чухал. Өөрчлөлт, шинэчлэлтийн хамрах цар хүрээ нь том бөгөөд хүнд зорилт юм. СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загварт томоохон зорилт тавьж түүнд хүрэхэд чиглэгдсэн үйл явцын иж бүрэн зураглалыг үзүүлж өгсөн. СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загварыг ирээдүйн хөгжлийн боломжийг олж харах хэрэгсэл болгон ашиглана.

СЗХ-ны стратегийг агуулсан гүйцэтгэх ажлын урсгалын загварыг дараах байдлаар загварчилсан:

Хүснэгт 9: СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар




Зохицуулалтын шинж чанартай гурван үндсэн стратегийн шийдвэр нь өөрийн эрхэм зорилго, стратегийн зорилтоо биелүүлэхэд чиглэгдсэн гүйцэтгэх ажлын урсгалын загвар боловсруулахад хүргэсэн:

- Үндсэн үйл ажиллагааг туслах үйл ажиллагаанаас ангилан ялгаж авч үзэх;
- Үндсэн үйл ажиллагаанд хамрагддаг бодлого боловсруулах болон хяналт тавих үйл ажиллагааны ялгааг гаргах;
- Хяналт тавих эрх мэдлийг аль болох гадна талын тоглогчид буюу мэргэжлийн холбоодод шилжүүлэх.

Харин туслах үйл ажиллагааны стратегийн тухайд хамгийн боломжит үр ашиг бүхий орчинд зохицуулах стратегийг хэрэгжүүлэх нөхцлийг хэрхэн хангах асуудлаас бүрдсэн.

3.6. Үндсэн болон туслах үйл ажиллагааг ангилан ялгах буюу сегрегац хийсэн нь

Хүснэгт10: СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар (үндсэн болон туслах үйл ажиллагааны хоорондын ялгаа)



Харилцагч (туслах), хадгаламж эзэмшигчдийн (үндсэн) эрх ашгийг хамгаалах зорилготой уялдан СЗХ-ны эрх хэмжээний асуудлыг тодруулахын тулд үндсэн болон туслах үйл ажиллагааг ялган салгах шаардлагатай болсон. Уг үзэл баримтлалыг гаргаж ирэх болсон шалтгаан нь зохицуулалтын үйл ажиллагаа яригдах үед үндсэн болон туслах үйл ажиллагааг ангилан ялгаагүйгээс үүдэн будилах, эргэлзэн тээнэгэлзэх асуудалтай тулгарч байсан явдал байв:

- Зохицуулах үйл ажиллагаа санхүүгийн системийг бүхэлд нь хамгаалах, мөн санхүүгийн байгууллагад байршсан хадгаламжийн найдвартай байдлыг хангахад чиглэгдсэн тохиолдолд үндсэн үйл ажиллагаа гэж үзнэ;
- Үндсэн үйл ажиллагааны зохицуулалт гэдэг нь (жишээ нь хөрөнгийн хүрэлцээ, заавал байлгах нөөц, төлбөрийн чадварын үзүүлэлт гэх мэт) зохицуулалтын байгууллагууд санхүүгийн чадвартай байхыг шаардах үйл ажиллагааг хэлдэг бол туслах чанарын үйл ажиллагаа бизнесийг удирдан явуулахтай холбоотой зохион байгуулалтын асуудлыг авч үздэг.

Ажил, үүргийг ийнхүү ангилан ялгасан нь үр ашигтай дотоод хяналт зохицуулалтын тогтолцооны маш чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ингэснээр ажилтан бүрийн ур чадвар нь түүний гүйцэтгэхээр хүлээсэн ажлын чиг үүрэгтэй зөрчилдөхгүй байх боломжийг бүрдүүлдэг

Ажил хариуцагч хувь хүн болон багт тодорхой бус үүрэг хариуцлага ногдуулбал энэ нь зохистой бус арга хэмжээ авах буюу эсхүл зорилгодоо хүрэх цаг хугацааг удаашруулахад хүргэдэг. Зарим цөөн тохиолдолд, тухайн үйл ажиллагааны (жишээлбэл, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулах гэх мэт) нарийн төвөгтэй байдал, уг мөн чанар, цар хүрээндээ шалтгаалан үйл ажиллагааг зааглан ялгах боломжгүй тохиолдол гарч болдог.

Үндсэн үйл ажиллагааны зохицуулалт нь хадгаламж татан төвлөрүүлдэг байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалт, түүнд тавьж буй хяналт бөгөөд

эрсдэлтэй үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарласан шалгуур үзүүлэлтийг боловсруулж мөрдүүлэхийг хэлнэ.

Зохицуулалтын үндсэн үйл ажиллагааны зорилго нь хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийн найдвартай байдал, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад оршино. Дор дурдсан зах зээлийн зохицуулалтын үйл ажиллагааг “Үндсэн үйл ажиллагаа” гэсэн ангилалд багтааж байна. Үүнд:

- Үнэт цаасны зах зээл;
- Даатгалын зах зээл;
- Бичил санхүүгийн зах зээл;
- Банк (Банкны үйл ажиллагааны зохицуулалтын талаар одоохондоо шийдвэр гараагүй байгаа тул банкны үйл ажиллагааны зохицуулалтыг стратегийн шинж чанартай төсөл хэлбэрээр авч үзэж болох юм).

Туслах үйл ажиллагааны зохицуулалтад голчлон үйл ажиллагааны ил тод байдал, харилцагчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг авч үздэг. Туслах үйл ажиллагааны дүрэм, журам нь байгууллагын үйл ажиллагааг зохицуулах асуудлыг өөртөө агуулдаг, харин санхүүгийн системийг бүхэлд нь хамгаалах зорилго агуулдаггүй.

СЗХ-ны туслах үйл ажиллагаанд дор дурдсан үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- Компанийн засаглал;
- Эрсдэл, эрсдэлийн үнэлгээ;
- Гадаад харилцаа.

Компанийн засаглал нь зохицуулалттай зах зээлийн арилжаанд оролцогчдыг илүү хариуцлагатай, үр ашигтай үйл ажиллагаа явуулахад шаардлагатай стандарт, дэг журам тогтооход чиглэгдэнэ.

Эрсдэл, эрсдэлийн үнэлгээ нь аудитын болон үнэлгээний компаниудыг хүнд байдалд орохоос өмнө оношилж, эдгээх үүргийг давтах бус илүүтэй урьдчилан сэргийлэх үүрэгтэй байхаар өөрчлөгдөх ёстой.

Аудитын болон үнэлгээний компаниудын хийсэн эрсдэлийн үнэлгээгээр аливаа зөрчил дутагдал илрэхээс өмнө урьдчилан сэргийлэх үүрэгтэй байхаар өөрчлөгдөх ёстой

Гадаад харилцаа нь СЗХ-ны зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын санхүүгийн зохицуулалтад нийцүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг үндсэн болон туслах үйл ажиллагааны аль алинд хамруулан авч үзнэ.


3.7.Бодлого боловсруулах болон хяналт тавих үйл ажиллагааны зааг ялгаа

Хууль эрх зүйтэй холбоотой үйл ажиллагаа санхүүгийн бүх төрлийн зах зээлд хамаатай зохистой харьцаа, стандарт, дэг журмыг тогтооход идэвхтэй үүрэг гүйцэтгэнэ.

Мөрдвөл зохих стандарт, дэг журам нэг бүр тухайн зах зээлийн онцлогт тохирсон байх ёстой бөгөөд бодлогод тусгалаа олсон байх учиртай.

Хяналтын систем ямар байх нь бодлого хэрхэн тодорхойлогдохоос хамаарах бөгөөд түүнээс урган гардаг.

Хүснэгт 11 : СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар (Бодлого боловсруулах болон үндсэн үйл ажиллагааны хяналт хоёрыг ялган зааглах нь)



3.8.Хяналтын үйл ажиллагааг аль болох мэргэжлийн холбоодод шилжүүлэх

Зах зээл тус бүрийн хувьд хяналт тавих үүрэг бүхий мэргэжлийн холбоод байна:


- Мэргэжлийн холбоод;
- Хараат бус аудитор;
-

СЗХ нь мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, тухайлбал холбоодод хяналтын үйл ажиллагааг шилжүүлээд, харин тэднийг хянах хэлбэрээр ажиллаж болно. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн холбоод СЗХ-нд бүртгэлтэй, зохицуулалт бүхий компаниудын үйл ажиллагаанд хяналт тавина гэсэн үг юм.

СЗХ бүртгэлтэй компаниудын үйл ажиллагаанд хяналт тавих асуудлаар эцсийн хариуцлага хүлээх тул энэхүү ажил үүргийг бусдад шилжүүлэх асуудлыг санаачлахын өмнө мэргэжлийн холбоодын чадвар, чадавхийн талаар маш сайн таньж мэдэж авсан байх шаардлагатай.

Аливаа ажил үүргийг бусдад шилжүүлэх үйл явцад хийгддэгтэй нэгэн адил СЗХ бүртгэлтэй компаниудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, хяналтын чухам ямар ажил үүргийг шилжүүлж болох, ер нь тухайн үйл ажиллагааг шилжүүлэх нь зүйтэй эсэхээ тодорхойлно. СЗХ зөвхөн тодорхой ажил үүргийг шилжүүлж буй гэдгийг үргэлж сануулж байх ёстой. Харин СЗХ өөрийнхөө зайлшгүй гүйцэтгэх шаардлагатай ажил, үүргийг бусдад шилжүүлж үл болно.


Хүснэгт 12 : СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар (Хяналтын ажил үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх нь)



3.9.Хамгийн боломжит дээд хэмжээний үр ашиг бүхий орчинд зохицуулалт хийх боломж бий болгох

Туслах үйл ажиллагааны гурван гол хэлбэр болох Захиргаа аж ахуй, Мэдээллийн технологи, Хууль эрх зүйн чиглэлийн үйл ажиллагааг зохистой болгож, энэ нь улмаар үндсэн үйл ажиллагааны стратегид тодорхойлогдсон зохицуулах болон хяналт тавих ажил үүргийг биелүүлэхэд дэмжлэг үзүүлдэг болох ёстой.

Хүснэгт 13: СЗХ-ны гүйцэтгэх ажлын урсгалын загвар (Туслах чанарын үйл ажиллагааны стратеги хамгийн дээд хэмжээний үр ашиг бүхий орчинд зохицуулах үйл ажиллагааны стратеги хэрэгжих боломжоор хангах ёстой)



Олон нийтийн боловсрол болон судалгааг СЗХ-ны эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд илүүтэй хувь нэмэр оруулдаг болгох нь зүйтэй.

3.10. Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

Стратегийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх нь СЗХ-нд хийгдэх ямар нэг түвшний өөрчлөлтийн амин сүнс юм. Эрхэм зорилго, зорилтоо ухамсарлан ойлгодог ажилтнуудтай байгууллагын нэг болох уу? гэсэн асуулт анхлан тавих нь стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэхэд шаардлагатай чухал суурь болж өгнө. СЗХ өөрийн стратеги төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дараах зүйлүүд маш чухал. Үүнд:


- Удирдлагын бүрэн хэмжээний идэвхтэй дэмжлэг;
- Үр ашигтай харилцаа холбоо;
- Ажилтнуудын оролцоо;
- Байгууллагын чамбай төлөвлөлт;
- Стратеги төлөвлөлт хэрэгтэй болохыг нийтээр хүлээн зөвшөөрсөн байх.

СЗХ-ны үйл ажиллагааны стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд ажилтнуудын итгэл үнэмшлийг бий болгох зохион байгуулалттай орчныг бүрдүүлснээр СЗХ өөрийн стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх боломж бүрдэнэ. Ингэснээр өөрийн үйл ажиллагааны алс хэтийг харж чаддаг болоход туслалцаа үзүүлэх юм.

Стратегийн төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлэх үйл явцыг эхлүүлэхийн тулд СЗХ энэхүү стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх үйл явцыг удирдах манлайлагчийг томилох, манлайлагч нь хэрэгжилтийн үйл явцад удирдлага болон нийт ажилтнууд бүрэн оролцож буй эсэхэд бүрэн дүүрэн итгэл үнэмшилтэй байх ёстой юм.

Стратегийг хэрэгжүүлэх явцад маш олон тооны хөндлөнгийн шинж чанартай асуудлуудыг харгалзан үзэж туйлын болгоомжтой удирдан залах хэрэгтэй болно.

Хүснэгт 14 : СЗХ-ны үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх нь



Түүнчлэн СЗХ-ны удирдлагыг үйл ажиллагааны стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаархи стратегийн ач холбогдол бүхий мэдээллээр хангаж байх шаардлагатай. Энэхүү мэдээлэл нь гүйцэтгэлийн бүхий л холбогдох асуудлыг хамарсан, бодит үнэнд тулгуурласан, аливаа ашиг сонирхлын зөрчил агуулаагүй мэдээлэл байх ёстой. Удирдлагад танилцуулах мэдээлэл нь СЗХ-ны зохицуулалтын хүрээний бүхий л

байгууллагууд дүрэм журмыг хэрхэн мөрдөж буй, олон нийт аль хэр сэтгэл ханамжтай байгаа болох, байгууллагын дотоод үйл ажиллагааны үр ашиг, инноваци зэрэг санхүүгийн болон санхүүгийн бус асуудлыг хамарсан байна.

Роберт Каплин, Давид Нортон нарын боловсруулсан Гүйцэтгэлийн Шалгуур Үзүүлэлтүүд (ГШҮ) гэж нэрлэгддэг аливаа байгууллагын үйл ажиллагааны үр дүнг тооцоход ашигладаг багц үзүүлэлтийн системийг 1996 онд Харвардын Их Сургуулиас олон нийтэд зориулан хэвлэсэн бөгөөд энэхүү системийг СЗХ “КPI”-ийн хамт авч хэрэглэх нь зүйтэй. Учир нь энэхүү үйл ажиллагааны үр дүнг тооцох системийг СЗХ шаардлагатай



алхам хийх, шийдвэр гаргах зэрэгтээ ашиглана. ГШҮ-ийн систем нь стратегийн зорилтыг гүйцэтгэлийн цогц үзүүлэлттэй холбож өгсөн удирдлагын болон үр дүн тооцох систем юм.


Хүснэгт 2 : Төрийн байгууллагын Гүйцэтгэлийн Шалгуур Үзүүлэлтийн загвар

Хэрвээ дэвшүүлсэн зорилго нэг л ер бусын, чамин зорилго болж буруу ташаа ойлголт төрүүлэхүйц тодорхойлогдчихвол уг байгууллагын стратегийг хэрэгжүүлэх ажил тунхаглалын чанартай үзэл баримтлал мэт харагдаж хэрэгжүүлэхэд хэцүү болох талтай. Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх үйл явцыг хэд хэдэн жижиг үе шатанд хуваан авч үзэж илүү боловсронгуй болгохын тулд манлайлах үүрэг хүлээсэн удирдах ажилтан үе шат бүрт тохирсон гүйцэтгэл тооцох эцсийн хугацаа зааж өгөх явдал чухал бөгөөд шаардлагатай гэж үзвэл гүйцэтгэл гаргах цаг хугацаанд өөрчлөлт оруулж болно. Гэхдээ тухайн нэг ажил үүргийн үр дүнг гарган тайлагнах эцсийн хугацаа стратегийн хэрэгжилтийн үр дүнг тооцох хугацааны хүрээнд байх ёстой. Энэ нь СЗХ урт хугацааны томоохон цар хүрээ бүхий зорилгоо биелүүлэхийн сацуу богино хугацаанд хийж гүйцэтгэх ажлаа үр дүнд хүргэхэд нөлөөлөх ач холбогдолтой.

Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх төсөлд анхааран авч үзвэл зохих цаг хугацааны хувьд урьдчилан тодорхойлогдчихсон байдаг асуудал гэж бий. СЗХ жилийн төсвөө хэлэлцэх үедээ эдгээр гарцаагүй буюу зайлшгүй хийх ёстой хугацаат ажлуудыг авч үзэх ёстой бөгөөд энэ нь үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх, үр дүнд хүргэхэд тус дэм болох юм.

2012 оны хувьд дээр дурдсан чухал бөгөөд зайлшгүй гүйцэтгэх ажлын хугацаа:
Хүснэгт 36 : 2012 онд зайлшгүй хийх ажлууд

2012 оны тогтсон цаг хугацаат ажил



4.1.Зохицуулалтын үйл ажиллагааг бэхжүүлэх

Монгол улсын санхүүгийн систем нь үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч, даатгалын байгууллага, бичил санхүүгийн байгууллага зэрэг зах зээлийн оролцогчид болон эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн гүйлгээ болон мөнгөний бодлогын цар хүрээг тодорхойлдог СЗХ, Монголбанк гэсэн зах зээлийн зохицуулалт хийх үүрэг бүхий байгууллагаас бүрддэг.

Сайтар зохицуулалт бүхий систем санхүүгийн тогтвортой байдалд төдийгүй эдийн засгийн өсөлт, хөгжилт, ажлын байр нэмэгдэхэд нөлөөлдөг.


Зохицуулалтын гол анхаарал хандуулбал зохих асуудал нь аль нэг байгууллагын асуудлыг шийдэхэд бус харин системийг бүхэлд нь авч үзэх явдал юм. Зохицуулалт бүхий санхүүгийн салбар дор дурдсан гол зорилгыг агуулсан байх ёстой. Үүнд:

- Санхүүгийн системд итгэх итгэлийг батжуулан, системийн тогтвортой байдлыг дэмжих;
- Санхүүгийн чанартай үйлчилгээ үзүүлэх чадамж бүхий байгууллагуудад л үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосон байх;
- Зах зээлийн зохистой удирдлагыг дэмжин хөгжүүлэх, зохисгүй үйлдэл гаргасан тохиолдолд шийтгэл ногдуулах замаар харилцагчдын эрх ашгийг хамгаалах;
- Санхүүгийн байгууллагуудын найдвартай, тогтвортой байдлыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хууль тогтоомжийг мөрдүүлэх.

Зохицуулах үүрэг хүлээсэн байгууллагын эрх мэдлийн хүрээ болон хяналтын чанарыг сайжруулах шаардлагатай. Дэлхийн олон улс оронд мөрдлөг болгодогчлон арбитражийн зохицуулалтанд хамрах хүрээг багасгах замаар санхүүгийн зохицуулалтын системийг сайжруулах, зохицуулалт хийх эрх бүхий байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулах нөхцлийг бүрдүүлэх нь зүйтэй.

Хяналт шалгалтын үйл ажиллагаа нь тухайн зохицуулалтын хүрээний байгууллага болон системийг бүхэлд нь хамарсан эрсдлийн мөн чанар, цар хүрээ болон нарийн төвөгтэй байдлыг харгалзсан эрсдэлд суурилсан аргад шилжихэд чиглэгдсэн байх ёстой. ЭСХ-ын систем нь санал болгож буй хамгийн тохиромжтой үр дүн тооцох арга юм.

Хүснэгт 47 : Эрсдэлд суурилсан хяналтын зарчмууд



Эрсдэлд суурилсан хяналтын системийг зохицуулалтын хүрээний байгууллагуудын найдвартай үйл ажиллагаанд том хэмжээний эрсдэл учруулахуйц нөхцөл байдал, практикийг олж илрүүлэх, түүн дээрээ үндэслэн зохицуулалтын хүрээний байгууллагууд эрсдэлээ хэрхэн удирдаж байгааг үнэлж дүгнэн хяналт тавихад ашиглах зорилгоор гаргаж ирсэн хяналтын арга гэж тодорхойлдог. Үүний гол зорилго нь эрсдэлийг шууд хянах бус зохицуулалтын хүрээний байгууллагын эрсдэлээ удирдах чадавхийг үнэлж дүгнэхэд оршдог.

СЗХ олон улсын стандартыг ашиглан эрсдэлд суурилсан хяналтын зарчмыг боловсруулж нэвтрүүлэх, түүнийгээ Монголын санхүүгийн салбарын онцлогт нийцүүлэхийг зорин ажиллаж байна.

Өмнө дурьдсанчлан, эрсдэлд суурилсан хяналтын нь үйл ажиллагааныхаа эрсдэлийг цаг хугацаанд нь зохистой аргаар олж илрүүлэн, үнэлгээ өгч, хянаж, хэмждэг зохицуулалт бүхий компани тус бүрийн эрсдлийн удирдлагын системийн талаар ойлголттой болж, түүний хангалттай эсэхийг үнэлж дүгнэхэд илүүтэй ач холбогдол өгдөг.

Энэ нь зохицуулалтын хүрээний байгууллагууд эрсдэлээ үнэлж дүгнэдэг, шаардлага хангахуйц хяналтын төлөвлөгөөтэй, төлөвлөгөөгөө үр дүнд хүргэн хэрэгжүүлдэг байх зэрэг асуудлын хүрээг хамарсан байнгын шинж чанартай үйл ажиллагаа бөгөөд түүний гол шинж чанар нь уян хатан байх явдал юм.

Дараах хүснэгтэд уламжлалт болон эрсдэлд суурилсан хяналт хоёрыг хооронд нь харьцуулж үзүүлсэн байгаа.

Хүснэгт 58 : Уламжлалт болон эрсдэлд суурилсан аргын ялгаа

Уламжлалт арга	Эрсдэлд суурилсан арга
Үйл явдалд суурилсан хяналт	Үйл явцын баримжаатай хяналт
Үнэлгээг байнгын бус, үе үе хийнэ	Үнэлгээ байнгын шинж чанартай
Стандарт горим журам	Эрсдэл суурьтай горим журам
Өмнөх үеийн гүйцэтгэл	Ирээдүйг харсан үзүүлэлт
Эрсдлээс бултахад анхаарлаа хандуулдаг	Эрсдлийг бууруулахад анхаарлаа хандуулдаг

Эх сурвалж: Эрсдэлд суурилсан хяналтын тухай гарын авлага 2009 оны 1 сар

Зохицуулалтын стратегийг боловсруулах явцад олон хүчин зүйлийг анхааран авч үзэх шаардлагатай бөгөөд тэдгээрийн зарим нэг нь бусдаасаа илүү ач холбогдолтой байдаг.

Зохицуулалтын стратеги нь зарим нэг онцгой нөхцөл байдлыг анхааралдаа авах шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, бүхий л ач холбогдолтой гэсэн асуудал бүрийг нэг түвшинд тавих нь зохимжгүй гэсэн үг. Гэхдээ ихэнх асуудлууд стратеги бүрт нийтлэг гэж хэлж болно. Зарим нэгэн онц ач холбогдолтой, онцгой асуудлын талаар дор сийрүүлсэн болно.

4.2. Үндсэн үйл ажиллагааны стратеги

4.2.1. Үнэт цаасны стратеги

Үнэт цаасны салбарын хувьд стратегийн шинжтэй дараах дөрвөн асуудлыг тодорхойлсон:

- ҮЦХОУБ-ын стандарт, зарчмуудыг мөрдөн хэрэгжүүлэх замаар хууль эрх зүйн орчныг сайжруулж бэхжүүлэх;
- Зуучлалын зах зээлийн хувьсал өөрчлөлтийг танин мэдэх;
- Системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах;
- Үнэт цаас гаргагчдын олон улсын тэргүүн туршлагаас суралцах, амьдралд хэрэгжүүлэх.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын стандарт, зарчимтай уялдаа холбоотой эрх зүйн орчинг бий болгон бэхжүүлэх

СЗХ нь ҮЦХОУБ-ын гишүүн байгууллагуудтай одоогийн бүтцийн хүрээнд цаашид хэрхэн хамтран ажиллах талаар тохиролцсон. Үүнд:

- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, адил тэгш, үр ашигтай, ил тод зах зээлийг хөгжүүлэх, системийн эрсдэлийг анхааралдаа аван холбогдох арга хэмжээ авч байх зорилгоор олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, уялдаа холбоо бүхий зохицуулалт, хяналт шалгалтын стандарт боловсруулан мөрдөх;
- Мэдээлэл харилцан солилцох, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зах зээлийн хяналтыг сайжруулан бэхжүүлэх замаар үнэт цаасны зах зээлийн үнэнч шударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах;
- Зах зээлийг хөгжүүлэх, зах зээлийн дэд бүтцийг сайжруулах, зохицуулалтын оновчтой арга хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дэлхий нийтийн болон бүс нутгийн түвшинд мэдээлэл болон туршлага солилцож байх.

ҮЦХОУБ-ын Гүйцэтгэх хороо дотроо хоёр төрөлжсөн хороо байгуулаад байна. Эхнийх нь дэлхийн өндөр хөгжсөн, олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулдаг томоохон зах зээлийг зохицуулах үүрэг бүхий арван найман байгууллагаас бүрдсэн техникийн хороо бөгөөд олон улсын үнэт цаас, фьючерсийн гүйлгээтэй холбоотой зохицуулалтын гол гол асуудлыг үнэлж дүгнэх, эдгээртэй холбоотой шаардлагатай арга хэмжээ авах үйл

ажиллагааг зохицуулах зорилготой ажилладаг. Энэхүү хороо дор дурдсан томоохон хэмжээний зургаан асуудлыг хамарсан үнэлгээ хийгээд байна. Үүнд:

- Олон улсын нягтлан бодох бүртгэл, тодруулга хийх
- Хоёрдогч зах зээлийн зохицуулалт;
- Зах зээлийн зуучлагчдын үйл ажиллагааны зохицуулалт;
- Тогтоосон хэм хэмжээг мөрдөх, мэдээлэл солилцох;
- Хөрөнгө оруулалтын менежмент;
- Зээлийн зэрэглэл тогтоох байгууллагууд

Хоёр дахь төрөлжсөн Хороо нь шинэ тутам хөгжиж буй зах зээлийн асуудлыг хариуцсан ажлын хэсэг бөгөөд шинэ тутам хөгжиж буй зах зээлийн хөгжлийг дэмжих, баримталбал зохих минимум стандарт, зарчмыг тогтоох, гишүүн байгууллагуудын ажилтнуудад сургалт зохион байгуулах, харилцан мэдээлэл солилцох, технологи дамжуулалт хийх, туршлага солилцох боломжоор хангах замаар эдгээр орны үнэт цаас болон фьючерсийн зах зээлийн үр ашгийг дээшлүүлэх зорилготой ажилладаг.

Энэхүү хороо дараахи үйл ажиллагааны хүрээг хамарсан ажлын хэсгүүдийг байгуулсан:

- Хоёрдогч зах зээлийн зохицуулалт;
- Зах зээлийн зуучлагчдын үйл ажиллагааны зохицуулалт;
- Тогтоосон хэм хэмжээг мөрдөх, мэдээлэл солилцох;
- Хөрөнгө оруулалтын менежмент.

СЗХ эхний ээлжинд ҮЦХОУБ-ын гишүүнчлэлийн статусаа Б зэрэглэлээс А зэрэглэл рүү шилжиж, шат ахиулах, цаашлаад ҮЦХОУБ-ын стандартад нийцсэн зохицуулалтын үйл ажиллагаа явуулах зорилго тавиад ажиллаж байна.

Зуучлалын зах зээлийн хувьсал, өөрчлөлтийг танин мэдэхүй

Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв, брокер, дилерийн компани, хөрөнгө оруулагчид зэрэг олон тооны байгууллагууд энэхүү зах зээлийн харилцаанд оролцдог. Орчин үед үнэт цаасны арилжаа улам илүүтэй автоматжсан бөгөөд гар ажиллагаатайгаас өнөөгийн зайнаас арилжаанд оролцох хүртэлх үе шатыг дамжин хувьсан өөрчлөгдөж ирсэн.

Олон улсад, түүний дотор Монголд брокерын зах зээл нь банкны брокер эсхүл, интернет брокерын үйл ажиллагаанд шахагдаж, бараг л үгүйтэй адил болсон.

СЗХ өнөөгийн зохицуулалтын үйл ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээл энэхүү түүхэн хувьсалтай харьцуулан авч үзэж, ямар түвшинд байгааг сайтар ойлгож танин мэдсэн байх шаардлагатай.

Системийн эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх

Засгийн газрууд болон олон улсын байгууллагууд дэлхийн санхүүгийн систем “гинжин урвал” адил системийн эрсдэлийн талаар улам бүр санаа зовох болсон. Гэсэн хэдий ч системийн эрсдэлд хүргэдэг шалтгаан, системийн эрсдэлийг хэрхэн тодорхойлох,

түүнийг хэрхэн хянах нь зүйтэй талаар тогтсон нэгдмэл ойлголтгүй явж ирсэн нь энэхүү асуудлаар төөрөгдөл бий болгож нийтээрээ будилахад хүргэсээр байна.

Чухам яг ямар эрсдэлийг системийн эрсдэл гэж үзэх, ямар төрлийн системийн эрсдэлийг зохицуулах нь зүйтэй талаарх ээдрээтэй асуудал тайлагдаагүй оньсого хэвээр.

Өнөөгийн байдлаар ерөнхийдөө санал нэгдэж чадсан ганц асуудал гэвэл системийн эрсдэл гэдэг нь санхүүгийн системийн үйл ажиллагаа ямар нэг хэмжээнд тасалдахад хүрэхийг системийн эрсдэлд тооцох тухай ойлголт юм. Эдийн засгийн хямрал, эсхүл санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа зогсох зэрэг гацаа үүсгэсэн үйл явдал зарим үед “гинжин урвал” гэж нэрлэгддэг эдийн засгийн сөрөг үр дүнд хүргэдэг үр нөлөөг системийн эрсдэлийн үндсэн хүчин зүйл хэмээн тодорхойлсон байх нь олонтаа тааралддаг.

Эдгээр сөрөг үр дагавар санхүүгийн байгууллагуудын, өөр үгээр илэрхийлбэл зах зээлийн уналт буюу дампуурал хэлбэрээр илэрч болно. Нэг их анхаарал татахуйц биш ч гэлээ санхүүгийн байгууллагуудын ихээхэн хэмжээний алдагдал, санхүүгийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл нь системийн эрсдлийн үр дагавар байж бас болно. Аль ч тохиолдолд системийн эрсдлийн үр дагавар санхүүгийн байгууллагууд, зах зээл, эсхүл хоёуланд нь нөлөөлнө.

СЗХ чухам юуг системийн эрсдэл гэж үзэх, үндсэн параметруудыг тогтоох үндсэн дээр энэ ойлголтын талаархи төөрөгдлийг алга болгохыг зорих ёстой.

Компаниуд болон хэрэглэгчид зуучлагчаар, тухайлбал банкаар дамжихгүйгээр шууд хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө босгох оролдлого нэмэгдэхийн хэрээр санхүүгийн зах зээл болон зах зээлийн оролцогчид хоорондын харилцаанд, ялангуяа зах зээлд оролцогчдын хөрөнгийн чадавхид илүү анхаарлаа хандуулах шаардлагатай юм. Монголбанкнаас үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий банкуудад нэгдсэн хяналт тавих нь СЗХ-ны гол зорилтуудын нэг болох юм.

Бусад орны тэргүүн туршлага нэвтрүүлэх

Зах зээлд оролцогчдын бусад улсын сайн жишээнээс суралцан, амьдралд хэрэгжүүлэх боломжийг өргөтгөх үйл ажиллагаа олон улсын тэргүүн туршлагад нийцсэн байх нөхцлийг хангах үүднээс үнэт цаасны зах зээл илүү үр ашигтай, ил тод байх шаардлагатай. Энэхүү нөхцлийг хангах эсэх нь үнэт цаас гаргагчдын (хувьцаа эсхүл өрийн бичиг) зүгээс гаргаж өгч буй мэдээллийн чанараас үндсэндээ хамаарна. Жил болон хагас жилийн санхүүгийн тайлан, удирдлагын хугацаат тайлан-мэдээлэл, хэрвээ үнэт цаас гаргагчийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц буюу томоохон хэмжээний өөрчлөлт гарсан зэрэг тохиолдолд гаргах нь зүйтэй байдаг үе үе давтагддаг мэдээллийг нээлттэй болгох нөхцлийг тухайлбал, АНУ-ын 1993 онд батлан гаргасан Үнэт цаасны тухай хууль, эсхүл Европын холбооны 2010/78/ЕС тоот Захирамж (Европын Үнэт цаасны зах зээлийн

хороо/байгууллага-ыг ажиллуулж эхлэх тухай, ESMA) зэргийн дагуу тавигддаг шаардлагатай ижил түвшинд хүргэн сайжруулах хэрэгтэй байна.

Үнэт цаас гаргагчид найдвартай, иж бүрэн хэмжээний мэдээллийг гаргаж өгч байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд зохицуулалтын үйл ажиллагаа хангалттай түвшинд байх шаардлагатай.

4.2.2. Даатгалын стратеги

Даатгалын салбарын хувьд стратегийн шинжтэй дараах хоёр асуудлыг тодорхойлсон:

- Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт тавих зураглал гаргах;
- СЗХ-ны зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээдийг олж тогтоох.

Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт тавих зураглал гаргах

Төлбөрийн чадварыг үнэлэхдээ АНУ-д гэхэд үзүүлэлт хоорондын энгийн харьцаа тооцохоос эхлээд анхдагч хөрөнгийн дүнг эрсдэлд суурилсан өөрийн хөрөнгөд харьцуулах зэрэг нарийн төвөгтэй томъёо ашигласан тооцооны аргыг, Канадад өөрийн хөрөнгийн доод хэмжээ тогтоох, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт тогтоон мөрдүүлэх зэрэг аргыг ашиглаж ирсэн түүхэн уламжлалтай.

Харин 2005 онд Даатгалын хяналтын байгууллагын олон улсын холбоо (ДХОУБ)-ноос гаргасан журмын дагуу энэхүү үзэл баримтлалд өөрчлөлт хийн шинэ зарчмуудыг санал болгосон. Эдгээрийг дурдвал:

- Тааламжгүй буюу хүнд нөхцөл байдал тулгарсан үед даатгалын байгууллагын өөрийн бизнесийн багц, актив, зах зээлд эзэлж буй байр суурьт нь нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл болон богино, урт хугацаанд санхүүгийн байдалд нь нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлж дүгнэх динамик аргыг хяналт шалгалтанд ашиглах;
- Бизнесийн бүхий л төрлийн эрсдэлийг тухайн бизнесийн аль нэгэн төрөл хэлбэрийн түвшинд болон бизнесийн байгууллагынх нь (тухайлбал компаний эрсдлийн удирдлага гэх мэт) түвшинд цогцоор нь авч үзэх;
- Статистик үзүүлэлтийн үнэн зөв байдал, тодорхой бус эрсдэлийн зардал, хувилбаруудыг шалгаж үзэх зэрэг эрсдэлийг тусгайлан болон ил тод хэмжих аргыг хэрэглэх,
- Үнэлгээ хийхдээ тухайн нэг компани болон зах зээлийг бүхэлд нь хамруулсан зах зээлийн жишиг үзүүлэлтийг ашиглах;
- Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, эрсдэлийн маржин зэргийг хамарсан хамгийн оновчтой тооцооллын аргууд болох нөхцөлт аргыг хэрэгжүүлэх.

Төлбөрийн чадвар I нь Европын холбоонд мөрдөгдөж буй төлбөрийн чадварын өнөөгийн горимыг шинэчилж засварлан хэрэглэх бол Төлбөрийн чадвар II нь илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд заавал байх өөрийн хөрөнгийн хамгийн доод хэмжээ болон эрсдэлийг удирдах шинэ аргыг авч үзэх юм.

Төлбөрийн чадварын заавал байх өөрийн хөрөнгийн хамгийн доод хэмжээ дараах зорилгыг агуулна. Үүнд:


- Даатгагч өөрийн үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүргэх эрсдлийг бууруулах;
- Тухайн даатгалын компани үйлчлүүлэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргийг бүрэн хэмжээгээр биелүүлэх чадамжгүй болсноос үүдэн даатгуулагчдад учрах хохирлыг багасгах;
- Хяналтын байгууллага нь зохицуулалтын хүрээний байгууллагад эрт анхааруулга өгөх эрхтэй байх, ингэснээр өөрийн хөрөнгийн хэмжээ заавал байх хэмжээнээс буурсан тохиолдолд албадлагын арга хэмжээ авах;
- Даатгалын салбарын санхүүгийн тогтвортой байдлын талаарх олон нийтийн итгэлийг бий болгох.

Ихэнх тохиолдолд даатгалын байгууллагын БАЗЕЛ хэмээн нэрлэгддэг Төлбөрийн чадвар II нь банкны салбарт ашигладаг БАЗЕЛ II (Одоогийн БАЗЕЛ III) –той төстэй. Тухайлбал, санал болгож буй Төлбөрийн чадвар II нь гурван үндсэн тулгуур баганаас бүрдэнэ. Үүнд:

- **Нэг дэх тулгуур багана** тоон үзүүлэлтээс бүрдэнэ. Жишээ нь даатгалын компани дор хаяж хэдий хэмжээний өөрийн хөрөнгөтэй байх шаардлагатай болох гэх мэт.
- **Хоёр дахь тулгуур багана** даатгалын компанийн засаглал, эрсдэлийн удирдлагын болон даатгалын байгууллагын үр нөлөө бүхий хяналтын системтэй холбоотой мөрдвөл зохих шаардлага.
- **Гурав дахь тулгуур багана** шаардлагатай тодруулга болон ил тод байдлын асуудлыг хамаарна.

Хүснэгт 69 : Төлбөрийн чадвар I ба II –ийн харьцуулалт

Тогтоосон стандартын аль нэг түвшинд хүрч очихын өмнө СЗХ өөрийн хууль эрх зүйн орчныг Төлбөрийн чадвар I-тэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгнө.



Хэрвээ ямар нэг цоорхой байгааг олж тогтоовол Төлбөрийн чадвар I - ийг хангахын тулд явал зохихыг авч үзэх шаардлагатай. Төлбөрийн чадвар I-д тавигдах шаардлагыг

хангахад чиглэгдсэн горимыг мөрдлөг болгож чадсан гэж үзсэн тохиолдолд СЗХ Төлбөрийн чадвар II –т шилжих хэрэгцээ шаардлагын зураглал гаргах хэрэгтэй болно.

ДХБОУХ-ноос гаргасан удирдамж, зааварчилгаа нь даатгалын байгууллагын төлбөрийн чадварын журам зааврыг боловсруулахад баримтлах гол гол зарчмыг тусгасан. Санал болгосон төлбөрийн чадварын горимоос дурдвал:

- Даатгалын байгууллага богино болон урт хугацаанд бусдын өмнө хүлээсэн үүргээ найдвартай биелүүлэх асуудалд анхаарал хандуулсан;
- Эрсдэлд мэдрэмжтэй байх, тухайн нэг байгууллага болон системийг бүхэлд нь хамарсан ямар эрсдэл учирч болзошгүй талаар тодорхой тусгах, үүн дээрээ үндэслэн мөрдвөл зохих горим журамд заасны дагуу санхүүгийн зохистой харьцааны шаардлагыг тавьж байх асуудлыг хөндсөн;
- Эрсдэлийн төрөл тус бүрт тухайн байгууллагын болон системийн түвшинд авч үзсэн оновчтой зохицуулалтын зохистой харьцааны үзүүлэлт шаардлагыг мөрдүүлэх талаар тодорхой тусгасан;
- Санхүүгийн зах зээлийн мэдээлэл болон даатгалын мэргэжлийн шинж чанартай эрсдэлийн талаарх гар дор бэлэн байгаа үзүүлэлттэй уялдаа бүхий үнэлгээний аргачлал боловсруулж мөрдөх шаардлагатайг харгалзан үзсэн;
- Мэргэжлийн буюу техникийн шинж чанартай заалтуудын тодорхойлолтыг агуулсан (мэргэжлийн шинж чанартай заалтууд нь зохистой, найдвартай, бодитой байх шаардлагатай бөгөөд эдгээрийг бусад орны даатгалын байгууллага, системийн үзүүлэлттэй харьцуулалт хийхэд ашиглах, мөн эрсдэлийн маржинг тодорхойлсон байна);
- Даатгалын багц ямар байгаагаас үүдэн хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах зардлыг тооцох хамгийн бодит үнэлгээны аргыг хэрэглэхийг санал болгох, уг арга нь санхүүгийн зах зээлийн эрсдэлгүй хүүгийн түвшин, мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн талаар харгалзан үзсэн байх ёстой талаар дурдсан;
- Төлбөрийн чадварын хяналтын түвшингийн хүрээг тогтоож, хяналтын шат бүрт тохирсон хяналтын арга хэрэгслийг бий болгохыг зөвлөсөн;
- Стандартчлагдсан, илүү боловсронгуй цогц аргыг төлбөрийн чадварыг үнэлэхэд ашиглах, үүний дотор хэрвээ зүйтэй гэж үзвэл, өөрийн дотоод үйл ажиллагаанд хэрэглэх загвар бий болгохыг зөвшөөрсөн.

СЗХ-ны зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээдийг олж тогтоох.

Зах зээлийн тухайн сегментийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх мэдлийн цар хүрээг тодорхойлохын сацуу СЗХ тодорхой нөхцөлтэйгөөр даатгалын зах зээлийн ямар хяналтын чиг үүргийг чухам хэнд шилжүүлэх нь зүйтэй талаар шийдвэр гаргана.

Зах зээлд хяналт тавих гадны тоглогчдод боловсрол мэргэжил, мэргэшлийн түвшин, бие даасан байдал, асуудалд бодитойгоор хандах чадвар, үнэнч шударга

ажиллах боломж чадавхи зэрэг тодорхой стандарт шаардлага тавигдана. Хэдийгээр СЗХ болон гадны тоглогчид санхүүгийн тайланг баталгаажуулах зэрэг төстэй үйл ажиллагаа явуулах боловч тэд тодорхой ашиг сонирхлын үүднээс тухайн үйл ажиллагааг явуулна. СЗХ нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, харилцагч, үйлчлүүлэгч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг бол харин гадны тоглогчид хөндлөнгийн аудитор шиг тухайн компанийн хувь нийлүүлэгчдийн хувийн сонирхолд үйлчилдэг.

СЗХ нь гадны тоглогчид хангалттай хэмжээний чадавхитай, бие даасан байдлаа алдахгүй байх зэрэг нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авах шаардлагатай.

СЗХ болон гадны тоглогчийн чадавхи ямар түвшинд байгаагаас хамааруулан Хороо өөрийн хяналтын эрх мэдлээ шилжүүлэх үйл явцыг алгуур хийх нь зүйтэй.

4.2.3.Бичил санхүүгийн стратеги

Бичил санхүүгийн салбарын хувьд стратегийн шинжтэй дараах гурван асуудлыг тодорхойлсон:

- Хүртээмжтэй санхүүгийн салбарын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бичил санхүүгийн зохицуулалтын загвар боловсруулах;
- Бичил санхүүгийн газрын чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааг зохицуулдаг хууль эрх зүйн актуудыг боловсронгуй болгох;
- Эрх шилжүүлэх боломж, нөхцлийн талаар үнэлгээ хийх (зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээд болон холбогдох асуудлыг хамарсан).

Хүртээмжтэй санхүүгийн салбарын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бичил санхүүгийн зохицуулалтын загвар боловсруулах

Хүртээмжтэй санхүүгийн салбар бий болгох тухай алс хэтийн зорилго нь ядуу болон бага орлоготой иргэд, мөн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бүх төрлийн санхүүгийн үйлчилгээ хүртээмжтэй байх нөхцлийг бий болгохтой холбоотой ойлголт. Санхүүгийн байгууллагууд хамтран оновчтой санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нийт хүн амд санал болгох байнгын үйл ажиллагааг хүртээмжтэй санхүүгийн салбар гэж тодорхойлдог.

Үр ашигтай ажиллахын тулд хүртээмжтэй санхүүгийн салбар зүй зохистой бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын хүрээгээр хангагдаж дэмжигдсэн байх ёстой. Ерөнхийдөө, эдгээрийг дараах байдлаар сийрүүлж болно:

- Бүх өрх, аж ахуйн нэгжид хадгаламж, богино болон урт хугацаатай зээл, төлбөр тооцоо, дотоод, гадаад шилжүүлэг зэрэг өргөн хүрээтэй санхүүгийн үйлчилгээг боломжийн үнээр авах нөхцөл бүрдүүлэх;
- Санхүүгийн байгууллагуудын дотоод менежментийн систем нь зохистой удирдлагаар хангагддаг, салбарын гүйцэтгэлийн стандарт мөрддөг, гүйцэтгэлийн хяналт бүхий, үйл ажиллагаа нь ил тод, хариуцлагатай, зохицуулалтын систем нь оновчтой байх;

- Санхүүгийн болон байгууллагын түвшний тогтвортой байдлыг урт удаан хугацаанд санхүүгийн үйлчилгээ авах боломжоор хангах арга хэрэгсэл болгох;
- Боломжтой гэж үзвэл зардал багатай, олон төрлийн үйлчилгээнээс хэрэглэгчид сонголт хийх боломж нөхцлийг хангах үүднээс ижил төстэй төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хэд хэдэн байгууллагатай байх.

Ядуу, бага орлоготой иргэд, бичил, жижиг аж ахуйн нэгжид үзүүлэх санхүүгийн үйлчилгээ санхүүгийн салбарын маш чухал салшгүй бүрэлдэхүүн байх ёстой. Энэхүү салбар нь өөр өөрийн гэсэн давуу тал, бизнесийн загвар бүхий олон төрлийн санхүүгийн байгууллагуудаас бүрдвэл зохилтой. Санхүүгийн салбарын үйлчилгээ нь хувийн хэвшилд хамаарах бөгөөд харин зохистой орчин нөхцлийг хангах нь төр, засгийн үүрэг юм.

Салбарын хөгжлийн хандлага нь хүртээмжтэй санхүүгийн салбарыг бий болгох боломжийг ашиглах, саад тотгорыг арилгах, цоорхойг нөхөх зэрэгт чиглэгдсэн уян хатан арга хэрэгсэл, хэлбэрээр ашиглагдана. Энэхүү үйл явц нь дараах үндсэн үе шаттай байна:

- Ядуу болон бага орлоготой иргэд санхүүгийн үйлчилгээнд хамрагдахад учирч буй макро, месо болон микро түвшин дэх саад бэрхшээл, санхүүгийн үйлчилгээнд хамрагдахтай холбоотой гол гол боломж бололцоо зэргийг хамарсан асуудлаар салбарын тойм судалгаа хийх;
- Дээр дурдсан гурван түвшинд оршин буй цоорхойг нөхөх зорилгоор гаргасан сонирхогч талуудын (хандивлагчдыг оруулаад) санал, санаачлагыг үнэлж дүгнэх;
- Монгол улсад хүртээмжтэй санхүүгийн салбар бий болгоход чиглэгдсэн дээрх судалгаан дээр үндэслэн Үндэсний бичил санхүүгийн стратеги, эсхүл Үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулах.

Санхүүгийн салбарын хөгжлийн хөтөлбөр нь санхүүгийн жижиглэнгийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад үйл ажиллагаа явуулах таатай орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Санхүүгийн жижиглэнгийн үйлчилгээ эрхлэгч байгууллагад арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, бичил санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгалын үйлчилгээ эрхлэгч, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэгч, үүрэн сүлжээний оператор, бусад санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд орно. Энэхүү арга зам нь аудит, зээлийн зэрэглэл, сүлжээ зэрэг санхүүгийн месо түвшний цоорхойг нөхөх, түүнчлэн санхүүгийн систем хүртээмжтэй байхад саад учруулж буй бодлого, хууль эрх зүй болон зохицуулалтын шинжтэй хязгаарлалтыг арилгахад чиглэгдсэн оролдлого юм. Үүний үр дүнд тухайн улс орны бодит нөхцөл байдалд нийцсэн динамик үйл явц явагдах болно.

Хүртээмжтэй санхүүгийн салбар бий болгох нь нарийн төвөгтэй зорилт бөгөөд тусгайлсан шинжилгээ шаардсан ажил юм. Олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бүгд өөр өөрийн давуу талдаа тулгуурлан энэхүү салбарт-суурилсан аргыг амьдралд хэрэгжүүлэх үйл явцад хувь нэмрээ оруулах хэрэгтэй болно. Салбарт суурилсан аргыг хэрэглэхэд СЗХ үйл явцыг хөхүүлэн дэмжих, зохицуулах үүрэг гүйцэтгэнэ.

Хүртээмжтэй санхүүгийн салбарын нэг чухал онцлог нь санхүүгийн үйлчилгээ хүртээмжтэй буй эсэхийг тухайн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх зүйн статус ямар байхаас бус харин тухайн байгууллагын хэмжээнээс нь хамааруулан авч үздэгт оршдог. Энэ нь санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ эрхлэгчээр үйлчлүүлэх боломж, хүртээмж илүүтэй бий болдог.

Тийм ч учраас СЗХ санхүүгийн байгууллагуудын эрх зүйн байдал ямар байхыг харгалзах бус харин тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ, хэмжээ ямар байхаас хамаарч хяналт тавьж зохицуулж байх ёстой. Зарим улс оронд энэхүү практик амьдралд хэрэгжиж эхлээд байна.

Бичил санхүүгийн газрын чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааг зохицуулдаг хууль эрх зүйн актуудыг боловсронгуй болгох

Өнөөгийн Монгол улсад бичил санхүүгийн зохицуулалтын дүр төрх ББСБ болон ХЗХ-ны үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомжоос урган гарсан байдаг хэдий ч эдгээрт бичил санхүүгийн үйл ажиллагаатай холбоогүй асуудлын талаар мөн авч үзсэн байдаг.

ББСБ-ын болон ХЗХ-ны салбарын хууль тогтоомжийг Монгол улсын тухайн салбаруудын онцлогтой уялдуулан сайжруулах арга хэмжээг авах нь зүйтэй бөгөөд энэ нь бичил санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчинг нэгдсэн зохицуулалтын хүрээнд авч үзнэ гэсэн үг биш юм.

Эрх шилжүүлэх боломж, нөхцлийн талаар үнэлгээ хийх (зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээд болон холбогдох асуудлыг хамарсан)

Бичил санхүүгийн үйл ажиллагааг хянах стратегийг боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарвал зохих асуудлууд даатгалын зах зээлийнхтэй адил байна. СЗХ боломжтой ямар этгээдэд өөрийн зарим эрх, үүргээс тогтоосон нөхцөл, болзолтойгоор хэрхэн шилжүүлэх талаар шийдэх ёстой.

4.2.4.Банкны стратеги

СЗХ-ны зохицуулалтын чиг үүрэгт банкны үйл ажиллагааг зохицуулах асуудлаар шийдвэр хараахан гараагүй ба банкны хяналт шалгалтын эрх үүрэгтэй холбоотой ажлыг стратеги боловсруулж хэрэгжүүлэх хэлбэрээр хийж гүйцэтгэх нь зүйтэй.

4.3.Туслах буюу үндсэн бус үйл ажиллагааны стратеги

4.3.1.Компанийн засаглалыг хөгжүүлэх стратеги

СЗХ нь компанийн засаглалыг хөгжүүлэхэд стратегийн шинжтэй хоёр асуудлыг тодорхойлсон. Үүнд:

- Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, компанийн засаглалын зарчмыг үндэсний түвшинд мөрдүүлэх

- СЗХ-г Компанийн сайн засаглалын үлгэр жишээ болгох

Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 3 сарын 9-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд уг тогтоолоор дор дурдсан арга хэмжээ авах замаар энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг СЗХ-ны даргад зөвлөмж болгосон:

- Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх эхний үе шатанд авбал зохих арга хэмжээ буюу хийх ажлын төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилтэнд хяналт тавих;
- 2011 оны Төсвийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлт буюу төсвийн тодотголд энэхүү Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг тусгуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, өмнөө тавигдсан зорилтыг биелүүлэхтэй холбоотой асуудлыг нийгэм эдийн засгийн хөгжлийн тухайн жилд тэргүүлэх ач холбогдол өгч буй зорилтод тусгаж, шаардлагатай эх үүсвэрийг СЗХ-ны тухайн жилийн төсөвт суулгаж өгөх;
- Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой асуудлаар хандивлагч байгууллага, олон улсын байгууллага, гадаад улсын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах.

Түүнчлэн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулахыг зөвлөсөн.

Энэхүү зөвлөмжийг ажил хэрэг болгох зорилгоор СЗХ 2011 оны 6 дугаар сард Компанийн засаглалыг хөгжүүлэх алба байгуулаад байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх хөтөлбөрийн нэгэн чухал тулгын чулуу нь хөтөлбөр хэрэгжихэд шаардлагатай хууль эрх зүйн болон эдийн засгийн орчин нөхцлийг бүрдүүлэх явдал тул үүнийг компанийн засаглалыг хөгжүүлэх хөтөлбөрийн хамгийн шийдвэрлэх ач холбогдолтой асуудалд тооцсон нь дэс дарааллын хувьд зөв зүйтэй шийдэл болсон. Одоо уг стратегийн бүрэлдэхүүн хэсгийг макро болон месо түвшинд өөрөөр хэлбэл хөтөлбөрийн бодлого болон дэд бүтэцтэй холбоотой асуудлыг боловсруулах хэрэгтэй байна.

Микро түвшингийн хувьд хамгийн түрүүнд зах зээлийн зохицуулалт бүхий байгууллагуудад гол анхаарлаа хандуулах ёстой. Үйл ажиллагааны загварт тусгаснаар компанийн засаглалыг хөгжүүлэх стратеги нь гадны байгууллагуудтай хамтарч хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх түншлэлийг бий болгоно.

Тэдгээр байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаандаа компанийн засаглалын зарчим болон ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөж ажилласан байх хэрэгтэй. Энэ талаас нь авч үзвэл, Үндэсний зөвлөлийн ажил хэрэг зохион байгуулалт сайтай байх, зөвлөл болон хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа хоорондын харилцан уялдааг хангах үүднээс эдгээр байгууллагуудтай байнгын харилцаа холбоотой ажиллаж тэдгээрийн ажлын чанарт үнэлэлт дүгнэлт өгч байх явдал чухал юм.

Мэдээллийн ил тод байдлыг хангах нь тогтсон стандарт, зарчмуудыг мөрдөж ажиллах боломжоор хангасан чухал урьдчилсан нөхцөл болно. Мэдээлэл нь бүхий л оролцогч талуудад нээлттэй байх ёстой. Гэхдээ мэдээлэл дамжуулж буй талын мэдээллийн чанарын хяналтанд нөлөөлөхүйц бус, интернэтэд суурилсан, өөрийн гэсэн портал сайттай байх нь хэрэгцээтэй мэдээлэлтэй танилцах, олж авах боломж олгосон хамгийн зөв зүйтэй арга байх болов уу?

Санхүүгийн Зохицуулах Хороог Компанийн сайн засаглалын үлгэр жишээ болгох

Компанийн засаглал нь төр болон хувийн хэвшлийн байгууллагуудад ялгаагүй хэрэгжиж байх ёстой байдаг.

Олон нийтээс төр, засгийн байгууллагыг сайн засаглалтай, ёс зүйтэй, хууль тогтоомжоо мөрдөж ажиллахыг шаарддаг.

Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд ерөнхийдөө холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өөрийн үйл ажиллагаагаа тайлагнаж, бусад байгууллагуудтай гэрээ болон харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж ажиллахаас өөрөөр бусад засаглалын ямар нэг онцгой шаардлага хангах үүрэг хүлээдэггүй.

СЗХ-д засаглалыг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэх боломж, орон зай бий. СЗХ-ны засаглалыг хөгжүүлж сайжруулах, түүнийгээ хэвшүүлэхэд иж бүрэн цогц, үр ашигтай, бат бөх засаглалын хууль эрх зүйн болон бусад үндэс суурь болсон дараах асуудлуудыг үйл ажиллагаандаа оруулж хэрэгжүүлэх явдал туйлын чухал юм. Үүнд:

- Захирлуудын зөвлөл/Удирдах зөвлөл-ийн эрх мэдэл, хорооны дүрэм журам;
- Зөвлөлийн эрхлэх ажлын хүрээ, чиг шугам болон мэдлэг боловсрол;
- Аудитын хорооны мөн чанар;
- Ёс зүйн дүрэм журам;
- Ил тод байдал, жилийн ажлын тайлагнал;
- Өөрийн жилийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ дүгнэлт.

4.3.2.Эрсдэл, эрсдэлийн үнэлгээний стратеги

Эрсдэл, эрсдэлийн үнэлгээний хувьд стратегийн шинжтэй дараах гурван асуудлыг тодорхойлсон:

- Зохицуулалт бүхий байгууллагуудтай холбоотой аудит, үнэлгээ, санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлсэн байх;
- Уул уурхайн актив/хөрөнгийг үнэлэх үнэлгээний стандарт тогтоох;
- Санхүүгийн салбарын үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн зохистой бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

Зохицуулалт бүхий байгууллагуудтай холбоотой аудит, үнэлгээ, санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлсэн байх

Дараах хоёр төрлийн стандартыг хэрэглэж болох юм. Үүнд:

- Олон улсын санхүүгийн тайлангийн стандарт (ОУСТС);

- Олон улсын аудитын стандарт (ОУАС).

Мөн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавихдаа олон улсын бусад стандартуудаас алийг нь авч суурь болгож хэрэглэхэд анхаарал хандуулах хэрэгтэй.

Уул уурхайн активын үнэлгээний стандарт

Одоогоор уул уурхайн активт үнэлгээ хийхэд ашиглах цогц стандарт байхгүй байгаа. Иймд, Канад, Австрали, Өмнөд Африк зэрэг улсад ашигладаг стандартын хүрээг эхний ээлжинд жишиг болгон хэрэглэж болох юм. Гэхдээ манай улсын уул уурхайн тодорхой нэг зах зээлийн хувьд дор дурдсан зарим нэг элементийг шинээр боловсруулж, тогтоох нь зүйтэй:

- Мэргэшсэн үнэлээч буюу үнэлгээний мэргэжилтэн;
- Үнэлгээний зарчмууд;
- Үнэлгээний арга, арга зүй;
- Ашигт малтмалын нөөц ашиглалт;
- Үнэлгээний тайлан–санал болгож буй агуулгын хүрээ.

Санхүүгийн салбарын үйл ажиллагааны эрсдэл, эрсдэлийн зохистой бодлого боловсруулж хэрэгжүүлэх

Олон улсын стандарт, тэргүүн туршлага, онолын судалгаа, СЗХ-ны бусад газар, хэлтэстэй зөвшилцөх үндсэн дээр санхүүгийн салбарын үйл ажиллагааны эрсдэлийг олж илрүүлэх, тодорхойлох, судалж шинжлэх, үнэлэх ажлыг хийж гүйцэтгэнэ. Эдгээр судалгаандаа тулгуурлан СЗХ-ны бусад холбогдох газар, хэлтэст дэмжлэг үзүүлэх бодлогыг тодорхойлно.

4.3.3.Гадаад харилцааны стратеги

Гадаад харилцааны хувьд стратегийн шинжтэй дараах асуудлыг тодорхойлсон:

СЗХ-ны ерөнхий чадавхийг сайжруулахын тулд гадаад түнштэй харилцаа холбоо тогтооход анхаарлаа төвлөрүүлэх.

СЗХ-ны чадавхийг сайжруулах зорилгоор гадаад түншүүдтэй харилцах харилцаанд анхаарлаа төвлөрүүлэх

Гадаад харилцааны стратеги нь Хорооны стратегийн шинж чанартай бодлогын баримт бичиг болон түүний хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ төсөл, хөтөлбөр санаачлах, боловсруулахаас эхлэн гинжин хэлхээс (үүнд олон улсын чанартай семинар, сургалт зэрэг чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа орох) бүхий үйл ажиллагааг хамаарна. Түүнчлэн, хэрэгжиж буй болон шинээр эхлэн хэрэгжүүлж буй төсөл тус бүрийн уялдааг хангах явдал чухал юм. Хэрэгжиж дууссан төслийн гүйцэтгэлийг хянах, үр дүнг нь зөв үнэлэх нь хэрэгжүүлж буй төслийн цаашдын хэрэгжилтэд тус дөхөм үзүүлэхийн сацуу чухал хувь нэмэр оруулна. Үүнээс гадна бас нэгэн анхаарал татахуйц

чухал асуудал бол олон улсын түнш байгууллагуудад зориулан гадаад хэл дээр цахим хуудсыг хөтлөх болон өдөр тутмын үйл ажиллагааг дамжуулах зэрэг зөв мэдээлэлийг өгч байх сувагийг бий болгох явдал юм.

4.4. Үндсэн болон туслах чанарын стратегийн аль алинд нь хамрагдах асуудал

4.4.1 Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний стратеги

Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний стратегийн шинжтэй дараах гурван асуудлыг тодорхойлсон:

- Эрсдэлд суурилсан хяналтын системийг үндсэн үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компаниудад зэрэглэл тогтоогч байгууллага /зээлийн болон компанийн засаглал/-ын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх;
- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг мөрдлөг болгох.

Эрсдэлд суурилсан хяналтын системийг үндсэн үйл ажиллагаанд нэвтрүүлэх

Хөгжлийн банк болон Зээлийн батлан даалтын сан нь эрсдэлд суурилсан хяналтад хамруулбал зохих байгууллагууд. Эдгээр байгууллагуудыг аль аль нь түргэн хурдацтай хувьсан хөгжиж буй санхүүгийн салбарын салшгүй хэсэг болгохын тулд хууль эрх зүйн болон хяналтын орчныг бүрдүүлэх шаардлагатай. Базелын тогтоосон журам, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа банкны салбарын зохицуулалт, мөн СЗХ-ны хяналт тавьдаг санхүүгийн бусад байгууллагуудын хэрэгжүүлж буй хяналтын аргатай уялдаа холбоотой байхаар тооцсон эрсдэлийн үнэлгээ хийж, дээрх байгууллагуудын үйл ажиллагааг хянах арга механизмаа тодорхойлох, мөн хяналтын “гүйцэтгэлд суурилсан” нийтлэг болон уламжлалт аргыг хэрэглэвэл зүйтэй байж болох юм.

Базелийн II ба III стандартууд хяналтын тоон болон чанарын үзүүлэлтүүдийг эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны онцлогыг харгалзсан үзүүлэлтийн харьцаатай нийцсэн байх тухай асуудлыг авч үзнэ. Гэхдээ Базел II-т тусгагдсан санхүүгийн салбарын гол тоглогчдын үйл ажиллагаанд хяналт тавихад хяналтын эрх үүрэг бүхий байгууллагууд гол үүрэг гүйцэтгэх асуудлыг баталгаажуулах ёстой. Үүний тулд үйл ажиллагаанд үнэлгээ хийх арга болон банк, санхүүгийн бусад байгууллагыг хэрхэн хянадаг талаарх тэргүүн туршлага зэрэгт суурилсан чанарын хяналтын аргыг мөрдөхөөр шийдвэрлэх төлөвтэй байна.

Хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компаниудад зэрэглэл тогтоогч байгууллага /зээлийн болон компанийн засаглал/-ын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх

СЗХ компанийн зэрэглэл тогтоох үйлчилгээний талаар судалгаа хийж, оновчтой нэвтрүүлснээр зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагааны хяналтын боломжит хэрэгсэл болгон ашиглана.

Зээлийн зэрэглэл тогтоох байгууллага нэг талаар зээлдэгч, зээлдүүлэгчийн хоорондох мэдээллийн тэгш хэмгүй байдлыг багасгадаг тул санхүүгийн зах зээлд чухал үүрэг гүйцэтгэдэг, нөгөө талаар компани эсхүл тухайн улс орны төлбөрийн чадвартайн илэрхийлэл болж өгдөг. Зээлийн зэрэглэл тогтоодог байгууллагын гүйцэтгэх үүрэг санхүүгийн даяарчлал явагдах хэрээр өсөн нэмэгдсэн бөгөөд Базел II–т тусгагдсан зээлийн эрсдэлийн түвшинг үнэлэх явдал түүнийг даган өсч, эрэлт ихтэй болсон.

Зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд шат дараалсан байх зарчмыг баримтлах бөгөөд Монголын нөхцөлд тохирсон, гэхдээ олон улсын стандартыг харгалзан үзсэн байх юм.

Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг мөрдлөг болгох

Аливаа улс орны эдийн засагт шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд хууль тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт оруулах, зохицуулалт хийхийг эрх бүхий байгууллагуудаас шаарддаг. Монголын өнөөгийн эдийн засгийн өндөр хурдацтай хөл нийлүүлэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхтэй холбоотой бодлого боловсруулах, санхүүгийн салбарын үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчинтой уялдуулах шаардлагатай. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрснээр гарах бодит үр дүн, үр нөлөөг үнэлж дүгнэхэд эрсдэлд суурилсан аргыг хэрэглэнэ.

5. ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

5.1. Захиргааны үйл ажиллагааны стратеги

5.1.1. Захиргааны ажил хэрэгт хамаатай үйл ажиллагааны стратегийн шинжтэй дараах дөрвөн асуудлыг тодорхойлсон:

- Олон нийт, байгууллагуудтай харилцах үйл ажиллагаанд мөрдөгдөх горим журмыг тогтоох;
- СЗХ-ны зохицуулалтын хүрээний тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын тухай мэдээллийн сан бий болгох;
- Цахим архивын систем бий болгох;
- Мэдээлэл нэг эх сурвалжтай байх систем тогтоох

Олон нийт, байгууллагуудтай харилцах үйл ажиллагаанд мөрдөгдөх горим журмыг тогтоох

Энэхүү үйл ажиллагаанд дэлхий нийтээр төр, засаг болон хувийн салбарын түвшинд түгээмэл ажиглагддаг аливаа төөрөгдөлд оруулсан, үнэнээс гажсан мэдээ мэдээлэл, нас, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, биеийн болон сэтгэхүйн буюу оюун ухааны хөгжлийн түвшин, хөгжлийн бэрхшээлтэй, мэдлэг, мэдээлэл олж авах боломжоор хязгаарлагдмал байдал зэргээр нь ялгавартай ханддаг, олон янзын санаа бодлыг сонсох хангалттай суваг байхгүй зэрэгтэй холбоотой асуудлыг гол суурь асуудал болгон авч үзнэ.

СЗХ олон нийт, байгууллагуудтай харилцах харилцааны горим журмыг тодорхой хэв маягт оруулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэх цаг мөч ирээд байна. Энэхүү горим журмын

зорилго, хамрах хүрээ, ерөнхий стандарт зэрэг нь түүний хамгийн анхлан авч үзвэл зохих бүрэлдэхүүн хэсгүүд нь байх юм.

СЗХ-ны зохицуулалтын хүрээний тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын тухай мэдээллийн сан бий болгох;

Зохицуулалтын хүрээний тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг бүрэн хангах, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр бүртгэх, нэгдсэн бүртгэлээс мэдээлэл, лавлагаа өгөх, цахим мэдээллийн санд бүрэн баяжилт хийх, мэдээдэлд тодорхой эрх бүхий этгээд нэвтрэхээр кодчилох, нэгдсэн мэдээлэл архивлан хадгалагдах зэрэг үйл ажиллагаанууд хийгдэнэ.

Тусгай зөвшөөрлийн бүртгэлийн программ нь СЗХ-оос олгогдож буй тусгай зөвшөөрөл, эрх бүхий байгууллага, иргэдийн бүртгэлийн программ байна. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, үйл ажиллагааны, дүрмийн сангийн болон салбарын өөрчлөлт зэрэг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын бүртгэл хөтлөгдөнө.

Мөн энэхүү мэдээллийн санд тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, гүйцэтгэх захирал, ТУЗ, нягтлан бодогч зэрэг мэдээлэл, тэдгээрт орсон өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Цахим архивын систем бий болгох

Баримтыг дижитал буюу цаасан хэлбэрээр хадгалах нь одоогоор эрхэлж буй үйл ажиллагаанд цаашдаа хэрэг болохгүй байж болох ч нягтлан бодох бүртгэлийн менежмент, эрх зүй, тоон мэдээллийн менежментийн хэрэгцээ шаардлагыг хангах, зохицуулалтын хэм хэмжээг мөрдөх, компанийн засаглалын шалгуурыг хангах зорилгоор ашиглагдаж байна. Шаардлагатай үед дижитал хэлбэрээр хадгалагдсан мэдээллийг ашиглан дотоодын хэлэлцүүлэг хийж цаг хугацаа хэмнэхэд түүхэн мэдээллээс архивлахын ач холбогдол оршино.

Цахим хэлбэрээр архивлах системд шилжсэнээр СЗХ цаас бага хэрэглэдэг байгууллага болоход нэг шат ахих боломж олгох бөгөөд дор хаяж хуучин баримт хадгалах шаардлагагүй болно. Хэдийгээр компьютер зэрэг электрон техник хэрэгсэл ихээр ашиглаж буй ч өдөр тутмын үйл ажиллагааны нэлээд хэсэг нь цаасан дээр үндэслэн явагдсаар байна. Түүнчлэн, ажилтнууд мэдээллийг анхааралтай уншиж судлах, уулзалтанд авч орох зэрэг зорилгоор хэвлэмэл баримт бичгийг ашиглах сонирхолтой байгаа нь цаас бага хэрэглэдэг байгууллага болоход учирч буй саад тотгор болж байна.

СЗХ цаасан хэлбэрийн баримт ашиглахаа багасгах, цахим архивын системийг баримт бичгийн менежментдээ ашиглахыг зөв зүйтэйд тооцоод байна. Цаас бага хэрэглэдэг байгууллага болохын тулд мэдээллийн цахим архивын системийг нэвтрүүлэх,

баримт бичгийг цахим хэлбэрт оруулан цахим файл үүсгэн хадгалах системтэй болох хэрэгтэй.

Цахим архивын системийн нэг чухал ач холбогдол нь цаас ихээр хэрэглэдэгтэй харьцуулахад зардал хэмнэх, ажилтнуудын цагийг хэмнэх, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлдэг сайн талтай.

Мөн мэдээллийн аюулгүй байдлыг илүүтэй хангах, болзошгүй гамшгаас хурдан хугацаанд сэргэх, байгаль орчныг бохирдуулахгүй байх, алсын зайнаас бизнесийн холбогдолтой баримт бичигтэй танилцах боломж олгодогт оршино.

Эдгээр шалтгааны улмаас СЗХ цахим архивын систем ашиглахыг зорьж байгаа болно.

Мэдээлэл нэг эх сурвалжтай байх систем тогтоох (Мэдээллийн агуулах)

Мэдээллийн агуулах нь ФИНА маягийн тухайн мэдээллийн эх хувийг олшруулж, олшруулсан хувиа хадгалах систем юм. Энэ нарийн төвөгтэй систем нь дараахи боломжийг олгодог:

- Мэдээллийн он цагийн хэлхээс бий болгох;
- СЗХ-ны бүхий л түвшинд нэг ижил мэдээллээр хангагдах, олон эх сурвалжаас ирсэн мэдээллийг нэгтгэх;
- Мэдээллийн чанарыг сайжруулах, хоорондоо уялдаа холбоо бүхий код, нэр төрөл бий болгох, шаардлагатай тэмдэглэгээ хийх, тэр бүү хэл зарим буруу зөрүү мэдээллийг засах ;
- СЗХ болон зохицуулалтанд хамрагддаг байгууллагуудын тухай мэдээллийг байнгын шинж чанартай болгох;
- Мэдээллийн эх сурвалжаас үл хамаарсан мэдээллийн ганц загвартай болох;
- Мэдээллийг хэрэглэгчид өөрсдийн сонирхолд нийцүүлэн бүтцийг нь өөрчлөн харж болдог болгох;
- Энэхүү систем нь мэдээллийн ашиглалтын системд нөлөөлөхгүйгээр шаардлагатай мэдээллийг, түүгээр зогсохгүй нарийн төвөгтэй анализ хийсний үндсэн дээр гаргадаг мэдээллийг хүртэл олж авч болох боломжоор хангана.

Зах зээлийн зохицуулалт бүхий байгууллагын тоо нэмэгдэх хэрээр зохицуулалт, хяналтын үйл ажиллагаа нэмэгдэнэ. Тийм ч учраас СЗХ мэдээллийг илүү сайн хянах боломж олгох мэдээллийн системийг нэвтрүүлэх явдал зайлшгүй шаардлагатай байгаа.

5.1.2.Хүний нөөцийн стратеги

Хүний нөөцийн стратегийн шинжтэй дор дурдсан асуудлыг тусгасан:

- Хүний нөөцийг хөгжүүлэх стратегийг боловсруулж хэрэгжүүлэх.

Хүний нөөцийг хөгжүүлэх стратеги боловсруулж хэрэгжүүлэх

СЗХ-ны үйл ажиллагааны стратеги болон хүний нөөцийн бодлогыг харилцан уялдаатай болгох зорилгоор 2011 оны 9 сард Хүний нөөцийг хөгжүүлэх асуудлыг тодорхойлох ажлыг эхлүүлсэн.

Өнөөгийн байдлаар, СЗХ-ны Тамгын газар ажилтнуудын мэдлэг, чадвар, дадлага, туршлагатай холбоотой асуудлыг хариуцан ажилладаг бөгөөд зөв хүнийг тохирох ажилд нь авч ажиллуулах зорилт тавин ажиллах ёстой. Шинээр ажилтан авахдаа журмын дагуу зөв хүнийг сонгон шалгаруулах ёстой байдаг. Тамгын газар шинээр ажилд орсон ажилтнаа сургаж дадлагажуулах, хөгжүүлэх, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг нь үнэлэн дүгнэх, нийгмийн асуудал, бусад холбогдох урамшууллын асуудлыг хариуцан ажилладаг.

Эдгээр асуудлаар дор дурдсан гурван тэргүүлэх чиглэлийн хүрээнд өргөн хүрээтэй ярилцлага хийсэн байна:

- СЗХ цаашид илүү олон тооны ажилтнуудыг сургаж дадлагажуулах, байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн ур чадвартай байх шаардлагын улмаас “Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах болон ур чадварыг дээшлүүлэх” тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх явдал чухал;
- Харилцан туршлага солилцох, гадаадын мэргэжилтнүүдийн мэдлэг, туршлагаас бусадтай хуваалцах боломж бүрдүүлэх зорилгоор “Ажилтнуудыг чадавхижуулах сургалтын стратеги” боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд газар, хэлтсийн удирдах ажилтнуудын үүрэг маш чухал тул тэдний чадавхийг улам дээшлүүлэх, түүнчлэн ажилтнуудад ямар төрлийн ур чадварыг хөгжүүлэх талаар удирдах албан тушаалтан, ажилтнуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, шаардлагатай байгаа ур чадварыг эзэмших боломж бүрдүүлэх нь зүйтэй;
- Дотооддоо харилцан туршлага солилцох, дотоод харилцааны соёлын хэм хэмжээ бий болгох, хэд хэдэн газар хэлтсийн ажилтнуудаас бүрдсэн ажлын хэсэг томилон ажиллуулах зэрэг нь удирдлагын соёл бий болгох зорилго бүхий Хүний нөөцийн асуудал хариуцсан газрын хамгийн чухал үүрэг байх болно.

Эдгээр ажлуудыг хийх нь байгууллагыг бүхэлд нь хамрах эерэг өөрчлөлтөд оруулах томоохон хувь нэмэр байх юм.

Энэ нь СЗХ-ны гол гол албан тушаалтнуудын анхааралд хүргэвэл зохих асуудал байх ёстой.

5.2. Мэдээллийн технологи

5.2.1. Мэдээллийн технологийн хамаатай үйл ажиллагааны стратегийн шинжтэй дараах дөрвөн чиглэлийг тодорхойлсон:

- Зохицуулалт, хяналтын ижил төстэй үйл явцыг боломжит төвшинд автоматжуулах;

- Мэдээллийн эх сурвалжийг шуурхай оновчтой болгож хялбаршуулан нэг эх сурвалж ашиглах горимд шилжүүлэх;
- Цаас ашиглалтыг багасгах бодлогыг хэрэгжүүлж, мэдээллийн нэгдсэн буюу цахим агуулах системийг боловсруулж нэвтрүүлэх;
- СЗХ-д мэдээллийг маш үр ашигтай удирдах боломж олгохуйц зохистой вэб дэд бүтцийг бий болгох.

Байгууллага нь сайн зохион байгуулалттай арын албагүйгээр ажлыг гүйцэтгэх боломжгүй тул дээр дурдагдсан дөрвөн чиглэл нь Удирдлагын мэдээллийн системийг мэргэжлийн төвшинд боловсруулж суурилуулах зорилгыг агуулна.

Зохицуулалт, хяналтын ижил төстэй үйл явцыг боломжит түвшинд автоматжуулах

СЗХ-д тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийг нягтлан тодруулах, зохицуулалтын хүрээний байгууллага, иргэдийн статистик үзүүлэлт болон эрсдэлийн үнэлгээг нэгтгэх зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг гар аргаар гүйцэтгэж байгаа нь маш их цаг хугацаа шаарддаг. Ижил төстэй буюу тогтмол үйлдэгддэг ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж автоматжуулснаар СЗХ их хэмжээний мэдээллийг үр ашигтайгаар боловсруулах чадавхитай болж, үйл ажиллагаа нь шуурхай явагдах боломжийг бүрдүүлнэ.

Мэдээллийн эх сурвалжийг хялбарчлан шуурхай оновчтой болгох, нэг эх сурвалж ашиглах горимд шилжүүлэх

Орчин цагийн бизнест олон төрөл, зорилгоос хамааран ихээхэн хэмжээний мэдээллийг удирдах, цэгцлэх, нэгтгэх, боловсруулалтыг хийхэд Удирдлагын мэдээллийн системийг ашиглаж байна. Энэхүү систем нь СЗХ-ны зүгээс өөрийн ажилтнууд болон зохицуулалтын байгууллага, иргэдийг хэрэгцээт мэдээллээр хангах, өөрийн мэдээллийн зохион байгуулалт, мэдээллийн урсгалтай холбоотой үйл явцыг оновчтой тогтоох, мэдээлэлд үндэслэсэн стратегийн шийдвэр гаргахад ихээхэн ач холбогдолтой юм.

Төвлөрлийг сааруулах нь нэгэн томоохон давуу тал, боломж мөн. Тухайлбал, хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг доод шатны менежерүүд хэрэгжүүлснээр газар, хэлтсийн удирдах ажилтнууд стратегийн ач холбогдол бүхий ажилд цагаа илүүгээр зарцуулах боломжтой болно. Түүнчлэн (УМС-ийг ашигласнаар) СЗХ-нд хэрэгжүүлж буй төсөл, тусгай хөтөлбөрүүдийн удирдлага зохицуулалт сайжирч, шийдвэр гаргагчид СЗХ-ны газар, хэлтэст тулгарч буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийн талаар тухайн цаг үеийн мэдээллээр тогтмол хангагдана.

Удирдлагын мэдээллийн системийг боловсруулж, залж удирдахдаа мэдээллийг нэгтгэх, зохицуулалт хийх, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ажилтнуудын хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахад нөлөөлөх чиглэл баримтлах шаардлагатай. Ингэснээр, бүх үйл ажиллагаа төлөвлөлт сайтай, гүйцэтгэлийг хэмжих арга оновчтой болохоос гадна өөрийн нөөц боломжийг үр ашигтай зарцуулах

боломж бүрдэж, хууль, тогтоомжийг мөрдүүлэхэд тавих хяналтын арга сайжрах юм. Удирдлагын мэдээллийн системийн хяналтын тусламжтайгаар төсөв төлөвлөгөөг үнэн зөв, нарийн боловсруулах, тооцоолол ба төлөв байдлын урьдчилсан дүгнэлт зэргийг гаргаж, ажилтнууд, дээд удирдлага болон зах зээлд оролцогчид нь амин чухал мэдээллээр хангагдана.

Цаас ашиглалтыг багасгах бодлогыг хэрэгжүүлж, мэдээллийн нэгдсэн буюу цахим агуулахын системийг боловсруулж нэвтрүүлэх

Өмнөх стратегийн чиглэл болон мэдээллийн сангийн бүтцийн архитектуртай нийцэх байдлаар ажил, үйл явцын урсгалын горимыг нарийвчлан боловсруулан нутагшуулах шаардлагатай. Чингэхдээ техник, тоног төхөөрөмжөөс гадна ажил хэргийн урсгал буюу хорооны үйл ажиллагааны шат дамжлага бүрийг нарийвчлан журамлан цогц байдлаар үе шаттайгаар нэвтрүүлэх нь зүйтэй.

Энэхүү систем нь ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийг илүү сайн, хурдан боловсруулах боломжийг баталгаажуулж өгнө.

СЗХ-д мэдээллийг маш үр ашигтай удирдах боломж олгохуйц зохистой вэб дэд бүтэц бий болгох

Виртуал хувийн сүлжээ (VPN) технологи ашиглавал СЗХ-ны ажилтнуудад ажлын байрны гаднаас дотоод системд холбогдох, улмаар яаралтай тохиолдолд биечлэн оролцохгүйгээр шийдвэр гаргах боломж бүрдэх юм.

Хяналтын үүрэг функцийн тухайд Виртуал хувийн сүлжээ нь газар дээрх хяналт шалгалтын үр ашгийг дээшлүүлнэ. Учир нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл авах, аливаа нэгэн зохицуулалтад хамрагдах байгууллагын мэдээлэлтэй зайнаас танилцаж баталгаажуулах боломжийг бүрдүүлсэн байна.

5.3. Судалгаа, шинжилгээний үйл ажиллагааны стратеги

Эдийн засгийн судалгаа шинжилгээ хийх нь СЗХ-ны үндэслэл сайтай бодлого боловсруулж хэрэгжүүлэх, санхүүгийн салбарын хяналт зохицуулалтын үйл ажиллагааг сайжруулахад чухал үүрэгтэй. СЗХ-ны ихэнх судалгааны ажлыг Хорооны судалгааны хэлтэс хийж ирсэн. Цаашид судалгааны хэлтэс санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын өнөөгийн болон ирээдүйн нөхцөл байдлын талаархи мэдээллээр хангах зорилгоор хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд практик ач холбогдол бүхий судалгааг хийх болно. Эдгээр судалгааны ажлууд СЗХ-ноос үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг санхүүгийн байгууллагууд эрүүл саруул байх нөхцлийг хангах зорилго агуулах бөгөөд эрсдлийн үнэлгээ хийх ба салбарын үйл ажиллагааг үнэлж дүгнэнэ. Мөн СЗХ-нд төрөөс хүлээлгэсэн үүргийг гүйцэтгэх хүрээнд судлаачид, мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчдын хооронд санал солилцох мэтгэлцээн хийхэд өөрийн хувь нэмрээ оруулна.

5.4. Эрх зүйн стратеги

5.4.1. Эрх зүйн стратегийн шинжтэй дараах гурван асуудлыг тодорхойлсон:

- Санхүүгийн зах зээлийг хянах, зохицуулах ажилд Мэргэжлийн холбоодын оролцоог нэмэгдүүлж нэгдсэн горимд оруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Зохицуулалтын хүрээнд гарсан хэрэг маргааныг арбитрын журмаар шийдвэрлэдэг болох;
- Аудит, хууль, үнэлгээний байгууллагын оролцоо бүхий хяналт зохицуулалтын бодлого, эрх зүйн хүрээг боловсруулах.

Санхүүгийн зах зээлийг хянах, зохицуулах ажилд Мэргэжлийн холбоодын оролцоог нэмэгдүүлж нэгдсэн горимд оруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх

СЗХ-оос санхүүгийн зах зээлийг хянах зохицуулахад чиглэгдсэн үйл ажиллагаанаас заримыг нь тухайлбал, мэргэжлийн сургалт явуулах, шалгалт авах, аттестатчилах, зайнаас хяналт тавих зэрэг ажлыг мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх, тэдгээртэй харилцан хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

Зохицуулалтын хүрээнд гарсан хэрэг маргааныг арбитрын журмаар шийдвэрлэдэг болох

Зохицуулалтын хүрээнд гарсан хэрэг маргааныг арбитрын журмаар шийдвэрлэдэг болох талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, зах зээлд оролцогч талууд тухайлбал, мэргэжлийн холбоодыг энэхүү үйл ажиллагаанд татан оролцуулах, эрх зүйн хувьд зохицуулалт хийж, хамтран ажиллана.

Аудит, хууль, үнэлгээний байгууллагын оролцоо бүхий хяналт зохицуулалтын бодлого, эрх зүйн хүрээг боловсруулах.

Санхүүгийн зах зээлд аудит, хууль, үнэлгээний байгуулагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлж, эрх зүйн орчныг сайжруулах, үйл ажиллагааг нь идэвхитэй дэмжих замаар чадавхижуулж бэхжүүлнэ.

5.5. Олон нийтийн сургалт ба олон нийттэй харилцах харилцааны стратеги

СЗХ нь олон нийттэй ил тод, нээлттэй харилцааг бий болгох, хууль тогтоомжийн мөрдөлт, аливаа мэдээллээр хангах, мэдээлэлтэй танилцах, хуулбарлан авах боломжоор хангах, интернетээр хайлт хийх боломжоор хангана. Энэ нь иргэд, байгууллагуудад хууль тогтоомж мөрдөж буй эсэх талаар мэдээлэл өгөхөд чиглэгдэх юм. Мэдээллийн нээлттэй байдал нь харилцагчын эрх ашгийг хамгаалах зорилготой хууль тогтоомж мөрдөх нөхцлийг хангаж, бизнесийн салбарын цаашдын өсөлт хөгжилд ихээхэн дэмжлэг болж өгнө.

Эдийн засгийн эрчимтэй өсөлттэй уялдуулан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг сайжруулснаар зохицуулалтын байгууллагуудаас хууль тогтоомж зөрчиж, хууль бусаар өөртөө давуу тал бий болгох асуудлыг халахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Ингэснээр төр засгийг эдийн засгийн өсөлтийг ч дэмжиж, иргэдэд шийдвэр гаргахад нь тус болохуйц мэдээллээр ч хангах олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг болгоно.

6.ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА


Эрсдэлийг харгалзан үзэж анхааралдаа авалгүй боловсруулсан стратеги ихэнхдээ өөрийн эрхэм зорилгодоо хүрч, стратегийн зорилтоо амжилттай биелүүлж чадахгүйд хүргэдэг. Эрсдэл нь стратегийг хэрэгжүүлэх үйл явцад саад тотгор учирч болох магадлал буюу боломж юм. Гэхдээ зарим эрсдэл тааламжтай хэрэгтэй зүйл байж ч болох, үүнийг тухайн байгууллага анхааралдаа авах нь зүйтэй бөгөөд хэрвээ эрсдэл тааламжгүй хор хохирол авчрахуйц бол түүнийг хөнгөрүүлэх, эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээ авах хэрэгтэй болдог.

Зохицуулалт хийх эрх үүрэг бүхий байгууллага болохын хувьд СЗХ эрсдэлийг удирдах цогц арга хэмжээн дээр үндэслэсэн эрсдэлийн шинжилгээ судалгаа хийдэг. Энэхүү арга нь хамгийн хүнд хэцүү эрсдэлийг үр ашигтай, үр нөлөө бүхий аргаар удирдан хянахад чиглэгдсэн үйл ажиллагааг СЗХ явуулдаг гэсэн итгэл найдварыг нийтэд төрүүлэхүйц эрсдэлийн удирдлагын хүрээг бий болгохыг шаарддаг. Эрсдэлийн ийм хяналтын бүтэц Хорооны гишүүд, ажилтнуудын эрсдэлийн удирдлагатай холбоотой гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхой болгож өгдөг.

Эрсдэлийн удирдлагын үйл явц нь үргэлжийн буюу байнгын шинж чанартай байх бөгөөд удирдлагын эргэн хянах систем хэлбэртэй, хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий шат дараалалтай байдаг:

- Олж илрүүлэх;
- Үнэлж дүгнэх, хэмжих;
- Юунд тэргүүлэх ач холбогдол өгөхөө тогтоох;
- Эрсдэлийн удирдлагын стратеги, тактикаа тодорхойлох;
- Хяналт үнэлгээ хийх;
- Хянан шалгах.

Хүснэгт 20 : Эрсдэлийн удирдлагын үйл явц



Давтамж, хор хохирол учруулах цар хүрээгээр нь ангилсан эрсдэлийн зураглал буюу матриц хийхэд шаардлагатай анхан шатны алхмыг юуны өмнө хийнэ. Тухайн эрсдэл хүлээн зөвшөөрөхөөр, эсхүл хүлээн зөвшөөрөхөөр бус, өөрөөр хэлбэл, хэрвээ эрсдэл үнэхээр бодитой байж болохоор бол тэрхүү эрсдэлийг байнгын хяналтандаа авч үнэлж дүгнэж байх хэрэгтэй асуудлыг зураглал хийхдээ анхаарна. Тухайн эрсдэл хүлээн зөвшөөрөхүйц бус бол байгууллага дараахи гурван сонголтын нэгийг хийнэ:

- Эрсдэлээс зайлсхийх;
- Эрсдэлийг хувиргах;
- Эрсдэлийг хөнгөрүүлэх буюу эрсдлийн түвшинг бууруулах.

Эрсдэлийн удирдлагын бодлого боловсруулах нь СЗХ-ны стратегийн нэг хэсэг бөгөөд дотроо хоёр үе шаттай стратегитай байх талаар анхаарч үзвэл зүгээр. Байгууллагын стратеги нь өөрийн гэсэн тусгай аргатай байхын зэрэгцээ хэд хэдэн төрлийн зохицуулах болон туслах шинж чанарын стратегитай байх шаардлагатай байдаг. Компанийн засаглалыг хөгжүүлэх стратегитай харилцан уялдаатай байх үүднээс Хорооны гишүүд дараахи асуудлаар үүрэг хариуцлага хүлээнэ:

- Олон улсын туршлага, төрийн байгууллагын удирдлагын зарчим зэрэгт нийцсэн байгууллагын түвшинд мөрдөх эрсдлийн удирдлагын эрх зүйн хүрээг тогтоох;
- Үйл ажиллагааны стратегидаа эрсдэлийг олж илрүүлэх, үнэлж дүгнэх, эрсдэлийг тэргүүлэх ач холбогдолтой эсэхээр нь ангилах асуудлыг хамарсан эрсдлийн удирдлагын циклийг тогтоох;
- Зохицуулах болон туслах үйл ажиллагааны стратегид таран байршсан эрсдэлийн удирдлагын эрх зүйн хүрээг Хорооны ажилтнууд мөрдөх нөхцлийг бүрдүүлэх;

- Хангалттай хэмжээний хатуу чанга дотоод хяналт, баталсан бодлого, журам, зааврыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Алсын хараа

Алсын хараа гэдэг нь тухайн байгууллага өөрийн ирээдүйг хэрхэн харж төсөөлж байгааг хэлнэ. Алсын хараа нь урт хугацааны зорилгын илэрхийлэл тул тухайн байгууллагын үйл ажиллагаагаа явуулах орчин ямар байхыг хүсч байгаагийн илэрхийлэл гэж үзэх нь ч бий. Жишээ нь, ядуучуудад туслах зорилготой ажилладаг буяны байгууллагын алсын хараа буюу хэтийн зорилго нь "Ядууралгүй дэлхий" байж болно.

Алсын харааны өгүүлэмж – Алсын харааг тодорхойлох нь

Алсын харааны өгүүлэмж нь тухайн байгууллагын хэн болохыг хүсч байгааг илэрхийлсэн байдаг. Энэ нь үндсэндээ ирээдүй рүү харж өөрийгөө зоригжуулж байгаагийн илэрхийлэл бөгөөд шийдвэр гаргахад ашиглах шалгуур болж өгдөг.

Эрхэм зорилго

Эрхэм зорилго гэдэг нь тухайн байгууллагын өмнөө тавьдаг гол зорилгыг агуулсан байдаг бөгөөд уг байгууллага яагаад оршин тогтнох ёстойн учир шалтгаан, алс хэтийн зорилгодоо хүрэхийн тулд чухам ямар үйл ажиллагаа явуулахыг тодорхойлсон байхыг хэлдэг. Зарим тохиолдолд тухайн байгууллагын ирээдүйн дүр төрхийг зураглан гаргасныг эрхэм зорилго гэх нь ч бий. Эрхэм зорилго нь өнөөг хүртэл юу хийж ирсэнийг харуулаад, "Бид юу хийдэг вэ?" гэсэн асуултанд хариулт өгдөг. Жишээ нь, буяны байгууллага "Орон гэргүй, ажилгүй хүмүүст" ажил эрхлэлтийн талаар сургалт хийх эрхэм зорилготой байж болно.

Эрхэм зорилгын өгүүлэмж - Эрхэм зорилгоо тодорхойлох нь

Эрхэм зорилгын өгүүлэмж тухайн байгууллагын үндсэн зорилгын илэрхийлэл болж өгдөг бөгөөд харилцагч хэн болох, ямар чухал үйл ажиллагаа явуулдагийг тодорхой харуулна. Мөн хүрэхээр зорьж буй ажлын үр дүнгийн талаар мэдээлнэ.

Байгууллагууд заримдаа өөрийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг Эрхэм зорилго эсхүл Алсын хараа хэлбэрээр илэрхийлдэг. Бусад зарим нь Алсын хараа болон эрхэм зорилгоо тодорхойлоод, тэдгээрийг үйл ажиллагааныхаа зорилго, зорилтыг тодорхойлоход ашигладаг.

Үнэт зүйлс

Байгууллагын гол үнэт зүйлс гэдэгт бид ажлаа хийж гүйцэтгэх, өөрсдийгөө залах, чиглүүлэхэд баримтлах үнэт зүйлсийг гэж ойлгоно. Бид маш олон тооны үнэт зүйлсийн ертөнцөд амьдардаг бөгөөд тэдгээрийн зарим нь дэндүү жижигхэн хэрнээ нийгэм, төр, засаг, улс төр, технологийн өөрчлөлт шинэчлэлтийн гэх мэт хүрээнд хамрагдсан маш чухал ач холбогдол агуулсан бидний баримталбал зохих гол суурь үнэт зүйлс хэвээр үлддэг.

Дэлхий ертөнц өөрчлөгдсөөр байвч гол суурь үнэт зүйлс өөрчлөгддөггүй. Гол суурь үнэт зүйлс бидний эрхэлдэг ажил төрөл, эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд хэрэглэдэг стратегийг тодорхойлдоггүй. Үнэт зүйлс нь бид ажлаа хэрхэн хийдэг, бид өөр хоорондоо хэрхэн харилцдаг, эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд бид ямар стратеги баримталдгийг харуулж өгдөг. Гол гол үнэт зүйлс гэдэгт бид эрхэлдэг ажлынхаа талаар ямар төсөөлөлтэй байдаг талаархи суурь элементүүд орно. Өөр үгээр илэрхийлбэл, энэ нь өдөр тутам бид юу хийдэг, эсхүл юу хийх ёстой тухай гэсэн үг.

Гол гол үнэт зүйлс нь бидний хоорондын хувийн харилцааг мөн залж чиглүүлдэг.

- Бизнесийн үйл явцыг чиглүүлдэг;
- Бид хэн бэ гэдгийг тодорхой болгодог;
- Бид юуны учир, юуны төлөө оршин байгааг илэрхийлж өгдөг;
- Бид бизнесийнхээ үйл ажиллагааг яагаад ийм арга замаар эрхлэн явуулдгийг тайлбарлахад тусалдаг;
- Бид бусдыг хэрхэн яаж сургах ёстойг зааж өгдөг;
- Бид хэрхэн амжилт олж болохыг мэдээлдэг;
- Бидэнд шийдвэр гаргах удирдамж болж өгдөг;
- Байгууллагыг бүхэлд нь бэхжүүлж өгдөг;
- Гадна талаас биднийг шүүмжлэх орон зайг багасгаж өгдөг;
- Хамгийн чухал зарчим, итгэл найдвар гэж хэлж болно

Юуг гол үнэт зүйлсэд тооцохгүй вэ:

- Үйл ажиллагааны практик дадал;
- Бизнесийн стратеги;
- Соёлын хэм хэмжээ;
- Чадвар;
- Зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгдөх/захиргааны өөрчлөлт
- Хувь хүний түвшинд л мөрдлөг болгодог үнэт зүйлс.

Стратегийг зарим тохиолдолд алс хэтийн зорилгоо биелүүлэхэд хэрэглэдэг үйл ажиллагааны зураглал гэж нэрлэх нь ч бий. Стратегийг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулбал зохих хамгийн чухал зүйл нь өөрийн байгууллагын хэтийн зорилгыг биелүүлэхэд тухайн компани/байгууллага зөв замдаа буюу ямар чиглэлд яваа гэдгийг баталгаажуулж байх явдал байдаг.

Үйл ажиллагааны стратеги

СЗХ ашгийн төлөө бус байгууллага тул түүний стратегийг үйл ажиллагааны стратеги гэж нэрлэсэн. Үйл ажиллагааны стратеги нь хороо санхүүгийн зохицуулагчийн эрх үүрэг бүхий байгууллага болохын хувьд өөрийн эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд сонгосон зам мөр юм. Зохицуулах болон туслах үйл ажиллагааны стратегиуд хамтдаа үйл ажиллагааны стратегийн салшгүй хэсэг нь.

Зохицуулах үйл ажиллагааны стратеги

Зохицуулах үйл ажиллагааны стратеги нь зохицуулах үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны процесс, зохицуулах үйл ажиллагааны хэм хэмжээнээс бүрддэг.

Зохицуулалтын үндсэн болон туслах чанартай үйл ажиллагаа

Зохицуулалтын үндсэн үйл ажиллагаа гэдэг нь санхүүгийн системийг бүхэлд нь болон санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэгч жижиг хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой зохицуулалтын үйл ажиллагаа юм. Хадгаламж авдаг байгууллага төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг буцаан олгож чадахгүйд хүрнэ. Хэрвээ томоохон хэмжээний байгууллага азгүйтвэл энэ нь олон нийтийн итгэл алдархад хүргэж, банкны систем бүхлээрээ хадгаламжаар дутагдах аюулд хүргэж болно. Тийм ч учраас зохицуулалтын үндсэн үйл ажиллагаа зохицуулах үүрэг бүхий байгууллагууд санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах оролдлого хийдэг.

Зохицуулалтын үндсэн үйл ажиллагаа байгууллагын эрүүл саруул байгаа эсэхийг сайтар ойлгож, хамгаалж байх ёстой тул харьцангуй хүнд, төвөгтэй бөгөөд өртөг өндөртэй байдаг. Туслах чанарын зохицуулалтын үйл ажиллагаа нь санхүүгийн системийг бүхэлд нь хамрах бус харин тухайн нэгэн байгууллагын бизнесийн үйл ажиллагааны зохицуулалтыг хангах горим журмыг тогтоодог.

Туслах үйл ажиллагааны стратеги

Туслах үйл ажиллагааны стратеги нь СЗХ-ны дотоод нэгжүүдийн ажлын хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны шат дамжлаг, мөн туслах үйл ажиллагааны хэм хэмжээг тодорхойлж өгдөг.

- Agence Française de Développement Département de la Recherche, 2009
Précis de réglementation de la microfinance
- СЯ, “Монгол Улсын эдийн засаг, санхүү төсвийн төлөв байдлын талаарх мэдээлэл”, 2012
- ҮСХ, Статистикийн товхимол, 2011 оны 6 сар
- ҮХШХ, 2012 он
- Танзаний Банк, 2009 он
Эрсдэлд-суурилсан хяналтыг хэрэгжүүлэх гарын авлага
- Бермудын Төв банк, 2011 он
Бизнес төлөвлөгөө
- Си Жи Эй Пи, 2002 он
Си Жи Ай Пи-ийн Бичил зээлийн удирдамж заавар: Бичил зээлийн хяналт, зохицуулалтын зарчим
- Си Ай Эм Ви Эй Эл –ийн стандарт болон заавар, 2003 оны 3 сар
Канад улсын уул уурхай, төмөрлөг, нефть болон эрдэс баялагийн институтын тусгай хорооны эрдэс баялагийг үнэлэх үнэлгээний стандарт болон журам заавар (CIMVAL)
- ЕвроАзиа Капитал, 2010
Монгол улсын хөгжлийн 2010-2020 оны төлөв байдал
- Санхүүгийн Бодлогын Форум – Дериватив судалгааны төв, 2004
Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын үндсэн үйл ажиллагааны давуу болон сул талууд
- Английн санхүүгийн үйлчилгээний байгууллага, 2007
Банк, Барилгын нийгэмлэг, Хөрөнгө оруулалтын пүүсүүдэд зориулсан шалгуур үзүүлэлтийн зарчмууд
- Английн санхүүгийн үйлчилгээний байгууллага, 2010
Арилжааны үйл ажиллагааны зохицуулалтын горимын тойм
- Английн санхүүгийн үйлчилгээний байгууллага, 2011
2011-2012 оны Бизнес төлөвлөгөө
- Фронттиер секюритиес, 2011 оны 8 сар
Монголын Макро эдийн засгийн өнгөрсөн өмнөх гүйцэтгэл болон ирээдүйн төлөвийн тухай тайлан
- HM Treasury, 2006
Төлбөрийн чадвар II: Европын Холбооны даатгалын зах зээлийн зохицуулалтын эрх зүйн шинэ хүрээ- Хэлэлцүүлэгт зориулсан баримт бичиг
- Олон улсын валютын сан, 2011
Монгол улсын санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээ, ОУВС-гийн тайлан, No. 11/107
- Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага, 2002
Хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох тухай Харилцан ойлголцлын санамж бичиг
- JERSY-гийн Санхүүгийн үйлчилгээний хянан шалгах хороо , 2010
2010-2012 оны бизнес төлөвлөгөө
- MIFA– Азид бичил санхүүг дэмжин хөгжүүлэх нь, 2009 оны 8 сар
Монгол улсын Бичил санхүү болон санхүүгийн салбарын судалгааны тайлан
- Өмнөд Африкийн Төрийн Сан, 2011
Өмнөд Африкийг хөгжүүлэхийн тулд санхүүгийн салбар найдвартай байх тухай
- Санхүүгийн арга хэмжээний ажлын хэсэг (FATF), 2009
Эрсдэлд-суурилсан арга: Амьдралын даатгалын салбарт мөрдөх журам заавар
- Нэгдсэн Үндэстний Байгууллага, 2008 оны 1 сар
Зээлийн зэрэглэл тогтоодог байгууллагууд болон тэдгээрийн хөгжиж буй улс орнуудад үзүүлдэг нөлөө – хэлэлцүүлэгт зориулсан баримт бичиг
- Нэгдсэн Үндэстний Байгууллага, Нью-Йорк, 2006
Хөгжлийн төлөө нийтэд хүртээлтэй санхүүгийн салбарыг бий болгох нь - Товч дүгнэлт

2012 оны /Арга хэмжээний/Үйл ажиллагааны төлөвлөгөө

Хорооны 2012 онд хийвэл зохих тэргүүлэх ач холбогдол бүхий ажлын талаар шийдвэр гаргахын тулд 2011 оны 12 сард зохион байгуулсан уулзалт ярилцлагын үр дүнг харгалзан авч үзсэн. Үүрэг хүлээсэн ажлын хэсэг 2012 онд үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх ач холбогдолтой төслүүд юу байж болох тал дээр анхаарч ажилласан.

2012 оны хамгийн гол зорилтот ажлын нэг нь ирэх 3-4 жилд Үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажил нэг бүрийг хамарсан зураглал гаргах явдал байх болно. Түүний зэрэгцээ 2012 он гэхэд зарим нэгэн амжилттай хэрэгжсэн төслийн талаар зарлана.

2012 оны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд:

Зохицуулах үйл ажиллагааны стратеги

- Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн стратеги
 - Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагийн гишүүнчлэлийн Б ангилалаас А ангилалд шилжихийн тулд МХБ-д бүртгэлтэй компаниудад тавигдах шаардлагыг чангатгах, боловсронгуй болгох, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагийн гишүүн орнуудын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулахаар идэвхи санаачлагатай ажиллах;
 - Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагийн тогтоосон зарчмууд дээр үндэслэн шинэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
 - Шинэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны процессын загвар боловсруулах.
- Даатгалын зах зээлийн хөгжлийн стратеги
 - Даатгалын зах зээлийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг төлбөрийн чадварын I болон II дахь шатны стандартуудыг үндэслэн үнэлж дүгнэх
- Бичил санхүүгийн зах зээлийн хөгжлийн стратеги
 - Бичил санхүүгийн хөгжлийн стратегийн дагуу Бичил санхүүгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулах
 - Шинэ хуулийг хэрэгжүүлэх шаардлагын үүднээс ХЗХ-дын чадавхийг дээшлүүлэх
 - Бичил санхүүгийн үйл ажиллагааны талаарх тодорхойлолт, уг үйл ажиллагааны онцлогийн талаар судалгаа хийх
 - Базел II –ийн стантартад нийцсэн зохицуулалт, хяналт хийх үйл ажиллагааны үнэлгээ (Эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх анхны алхам)
- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний стратеги

- Хөгжлийн банкны үйл ажиллагаанд мөрдөгдвөл зохих дүрэм, журмыг боловсруулж дуусгах
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх (Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль)
- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар баримтлах бодлогыг тодорхойлоход шаардлагатай тойм судалгаа хийх
- Компанийн засаглалыг хөгжүүлэх стратеги
 - Компанийн засаглалын **портал** сайт бий болгох. Энэ нь компанийн засаглалын бүхий л мэдээллийг агуулсан вэб сайтуудыг холбосон **портайл** сайт байх ба олон нийтэд их хэмжээний мэдээллийг богино хугацаанд олж мэдэх боломжийг олгоно
 - СЗХ нь Төрийн байгууллагын хувьд компанийн засаглалын зарчмын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт хийх.
 - Мэргэжлийн холбоодод зарим нэг чиг үүргийг шилжүүлэхтэй холбоотойгоор компанийн засаглалын үндсэн зарчмыг тодорхойлох.
- Эрсдэлийн үнэлгээний стратеги
 - Нягтлан бодох бүртгэл, аудит, үнэлгээний нийтлэг стандартыг тодорхойлох тойм судалгаа хийх
 - Уул уурхайн салбарт хэрэглэдэг үнэлгээний стандартыг мөрдөх
 - Зээлжих зэрэглэлийн судалгааны төсөл боловсруулах
 - СЗХ-ны зохицуулалт бүхий салбарын эрсдэлийн тодорхойлолтыг боловсруулж гаргах, хэрэгжилтэнд нь үнэлгээ өгөх
 - Санхүү, аудит, үнэлгээний тайлангийн чанарыг сайжруулахад чиглэгдсэн үр ашигтай бүтэц бий болгох
- Гадаад харилцааны стратеги
 - Төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны хүрээг сайжруулах
 - Энэхүү сайжруулсан хүрээнд төсөл, хөтөлбөрийн асуудлыг авч үзэж байх

Туслах үйл ажиллагааны стратеги

- **Захиргааны шинж чанартай үйл ажиллагааны стратеги**
 - Зөвшөөрөл авсан буюу лицензтэй байгууллагуудын тухай мэдээллийн сан бий болгоход хэрэгтэй үйл ажиллагааны шаардлагуудыг тусгасан баримт бичгийг боловсруулах (Мэдээлэл харилцааны технологийн хэсэгтэй уялдаатай ажиллана)
 - Э-архив-ын үйл ажиллагааны шаардлагуудыг тусгасан баримт бичгийг боловсруулах

- Бүхий л холбогдох асуудлыг хамарсан байхаар тооцож вэб хуудсыг шинэчлэх, агууламжийн удирдлагын систем тогтоох
- Вэб хуудасны менежменттэй холбоотой цогц баримт бичгийг боловсруулах
- **Хүний нөөцийн стратеги**
 - СЗХ-ны ажилтнуудын чадавхи дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах
 - СЗХ-нд шинээр орсон ажилтнуудыг дадлагажуулах хөтөлбөр боловсруулах
- **Эрх зүйн хүрээг боловсронгуй болгох стратеги**
 - Стратегийн ач холбогдол бүхий асуудлуудын хууль эрх зүйн үндсийг тодорхойлох
 - Хууль эрх зүйн чиглэлээр хэрэгжих төсөл боловсруулж хэрэгжүүлэх
 - Шийдвэр гаргахтай холбоотой төслүүд боловсруулж хэрэгжүүлэх (зохицуулалт, ажилд тохоон томилох, хяналт тавих зэрэг асуудлыг хамарсан)
 - СЗХ-ны 2006-2011 оны буюу одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй шийдвэрүүдийг нэгдсэн бүртгэлд авах

СЗХ-ны Үйл ажиллагааны стратегийг боловсруулахад хувь нэмрээ оруулсан хүмүүс:

СЗХ-ны үйл ажиллагааны стратегийг боловсруулахад шаардлагатай чухал элементүүд, санааг тодорхой болгоход шууд болон шууд бусаар оролцсон бүх хүнд баярлаж талархсанаа илэрхийлэхийг хүсч байна.

Санхүүгийн Зохицуулах Хороо

- Д. Баярсайхан Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга
- Б. Даажамба Хорооны дэд дарга бөгөөд гишүүн
- Г.Хэрлэн Хорооны дэд дарга бөгөөд гишүүн
- Д.Ганбаяр Хорооны гишүүн
- Х. Бум-Эрдэнэ Хорооны Ажлын албаны дарга
- Н. Туул ТГ-ын Захиргааны хэлтсийн дарга
- С. Тулгаа ҮЦГ-ын Үнэт цаас гаргагчдын хэлтсийн дарга
- П. Цэрэндэжид ДГ-ын Даатгалын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- О. Батбилэг Эрхзүйн хэлтсийн дарга
- А. Баянмөнх БСГ-ын Бичил санхүүгийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Б. Долгорсүрэн ЭҮССШБҮГ-ын Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлтсийн дарга
- В. Мандуул Мэдээлэл технологийн хэлтсийн дарга
- Л.Маамсүрэн ТГ-ын Захиргааны хэлтсийн ахлах референт

Монголбанк

- Н. Золжаргал Дэд ерөнхийлөгч
“Монголын хөрөнгийн бирж” ХК

- Билл Горман Ерөнхийлөгч
“ҮЦТТТХТ” ХХК

- Т. Гандулам Гүйцэтгэх захирал
Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо
“Монгол даатгал” ХХК

- А. Ариунзаяа Даатгалын менежер

Удирдлагын академи

- Ц. Өнөржаргал Профессор
Янер Глобал Ассошиэтс

- Дэмир Янер Зөвлөх
Люксембургийн Хөгжлийн агентлаг

- Ив Матью Ерөнхий зөвлөх

Масселотте

- Оливер Ноблот Захирал
Люксембургийн Даатгалын Зохицуулах Хороо (COMMASSU)

- Виктор Род Гүйцэтгэх хорооны дарга

Люксембургийн Банкны Зохицуулах Хороо (CSSF)

- Даниел Берна-Ост Ерөнхий нарийн бичгийн дарга

Люксембургийн Даатгалын Компаниудын Холбоо (ACA)

- Пол Де Кооман Даатгалын Компаниудын холбооны дарга АХА Люксембургийн Гүйцэтгэх захирал

Люксембургийн Цюрих Евролайф Эс Эй (Даатгалын компани)

- Хавиер Невез Ерөнхий хуульч